



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2022 • № 60

Н.Ариунбат:
Банкны нөлөө бүхий
хувьцаа эзэмшигч
болох тохиолдолд
Монголбанкнаас
зөвшөөрөл авах
шаардлагатай

Олон улсын
корреспондент
банкны
харилцааны
нөхцөл байдал

Bank IPO

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

БОДЛОГЫН ХҮҮГ ӨСГӨХ ТУХАЙ

Дугаар: 2022/02

Огноо: 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 3 дугаар сарын 23, 24-ний өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөвийг хэлэлцэн бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 9.0 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

Олон улсын харилцаанд хурцадмал байдал шинээр үүсэж, гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдлын нэмэлт эх сурвалж болж байна. Ийнхүү тодорхой бус байдал огцом нэмэгдэж, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, тэр дундаа газрын тос, хүнсний үнэ огцом өсөж, нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэхээр байгаагаас энэ онд инфляц өмнө нь төсөөлж байснаас нэмэгдэх, эдийн засгийн өсөлт саарах эрсдэл олон улс оронд бий болоод байна.

Жилийн инфляц 2022 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 14.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 15.5 хувьтай гарав. Инфляцад олон улсын зах зээл дээрх хүнсний болон шатахууны үнэ өссөн, тээвэр логистикийн саатал, түүнээс улбаатай тээврийн нэмэлт зардал, нийлүүлэлтийн доголдол зэрэг хүчин зүйлс нь голлон нөлөөлж байна. Инфляц 2 дугаар сараас алгуур саарч эхэлсэн нь өмнөх төсөөлөлтэй нийцтэй байсан хэдий ч олон улсад шинээр үүсээд буй хурцадмал байдалтай холбоотойгоор инфляцын төсөөлөл нэмэгдэж байна.

Цар тахлаас үүдэлтэй хязгаарлалт суларч худалдаа, үйлчилгээний салбар эдийн засгийн идэвхжлийг дэмжсэн хэдий ч хилийн хязгаарлалттай холбоотойгоор уул уурхай, тээвэр, барилгын үйлдвэрлэл буурснаас эдийн засгийн өсөлт өнгөрсөн онд хүлээлтээс бага гарлаа. Олон улсын харилцааны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өсөж, үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлэх, БНХАУ-ын ковидын эсрэг бодлоготой холбоотойгоор үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт хязгаарлагдаж байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөг 2022 онд үзүүлэхээр байна.

Үйлдвэрлэлийн зардлын өсөлтөөр дамжин зардлын инфляц бий болох, инфляцын хүлээлт өсөх, төлбөрийн тэнцэлийн алдагдал нэмэгдэхийн зэрэгцээ гадаад суурь хүү илүү хурдтай өсөх нөхцөл үүсэж байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг илүү хурдтай чангаруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байна. Цаашид гадаад, дотоод эдийн засгийн идэвхжил, инфляцын өрнөл, нийлүүлэлтийн хязгаарлалт, олон улсын харилцааны нөхцөл байдалтай уялдуудан мөнгөний бодлогын дараагийн алхмуудыг тухай бүр авч хэрэгжүүлэх болно.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

САНХҮҮГИЙН
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛ ЭЭЛЖИТ
БУСААР ХУРАЛДЛАА



07

ЯРИЛЦЛАГА

Н.АРИУНБАТ:
БАНКНЫ НӨЛӨӨ
БҮХИЙ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧ БОЛОХ
ТОХИОЛДОЛД
МОНГОЛБАНКНААС
ЗӨВШӨӨРӨЛ АВАХ
ШААРДЛАГАТАЙ



10

БАЙР СУУРЬ

БАНКНЫ
ЗАСАГЛАЛЫГ
БЭХЖҮҮЛЭХ НЬ ТУС
САЛБАРТ ХИЙГДЭЖ
БУЙ ШИНЭЧЛЭЛТИЙН
ТОМООХОН ЗОРИЛТ
ЮМ



14

АСУУЛТ, ХАРИУЛТ

ВАЛЮТЫН ЗАХ
ЗЭЭЛТЭЙ
ХОЛБООТОЙ АСУУЛТ,
ХАРИУЛТ



18

НИЙТЛЭЛ

ЭДИЙН ЗАСАГТ
МӨНГӨ ХЭРХЭН БИЙ
БОЛДОГ ВЭ?



22

**МОНГОЛБАНК ЮУ
ХИЙДЭГ ВЭ?**

БАНКНЫ САЛБАРЫН
РЕФОРМЫН
ХҮРЭЭНД
ХИЙГДСЭН ЭРХ
ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ



24

**МӨНГӨ УГААХ БОЛОН
ТЕРРОРИЗМТЭЙ
ТЭМЦЭХ**

ОЛОН УЛСЫН
КОРРЕСПОНДЕНТ
БАНКНЫ
ХАРИЛЦААНЫ
НӨХЦӨЛ БАЙДАЛ



34

СУДАЛГАА

КОВИД-19 ЦАР
ТАХЛЫН МОНГОЛ
УЛСЫН ЭДИЙН
ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН
НӨЛӨӨ

○ САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ЭЭЛЖИТ БУСААР ХУРАЛДЛАА

2022/03/01



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2022 оны 1 дүгээр улирлын ээлжит бус хурал 2 дугаар сарын 28-ны өдөр хуралдав. Хуралдааныг Сангийн сайд Б.Жавхлан даргалж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн болон холбогдох мэргэжилтнүүд оролцлоо. Тус хуралдаанаар “Орос, Украины цэргийн ажиллагааны манай улсын эдийн засагт үзүүлэх нөлөө”, “Монгол Улсын эдийн засгийн төлөв, зарим арга хэмжээний санал”, “Дэлхийн бусад улсуудаас ОХУ-ын эсрэг авсан төлбөр тооцооны хориг арга хэмжээнүүд” мэдээллүүдтэй танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэж, холбогдох мэдээллүүдийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв. Түүнчлэн, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс эдийн засгийн төлөв, гадаад орчинд үүсэж буй эрсдэлтэй уялдуулан макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх хүрээнд холбогдох бодлого, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулахаар тогтов.

○ ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2022” АЯНЫГ ХЭРЭГЖҮҮЛЭВ

2022/03/14



Олон Улсын Эдийн Засгийн Хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ (OECD/INFE)-ээс санаачлан хэрэгжүүлдэг “Дэлхийн Мөнгөний Долгоо Хоног” хүүхэд, залуучуудад зориулсан олон улсын аянд Монгол Улс 9 дэх жилдээ оролцож, 3-р сарын 14 – 28 –ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус аян энэ жил “Мөнгөө ухаалгаар удирдаж, ирээдүйгээ өөрөө бүтээе” уриан дор болов. Аяныг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ, Монголын Банкны Холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан, Зээлийн батлан даатлын сан, Арилжааны банкууд, Рио Тинто ХХК, Юнител групп, Lemon Press компани, Мобифинанс ББСБ хамтран хамтран зохион байгуулсан юм. Энэ үеэр хувь хүний санхүүгийн төлөвлөлт, ирээдүй рүү чиглэсэн хуримтлал ба хөрөнгө оруулалт, санхүүгээ оновчтой удирдах сургалт болон мэдээллийг олон нийтэд өгч, хүүхэд залуучуудыг хамарсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүллээ.

○ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧДОД ЗОРИУЛСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2022/03/28



Монголбанкнаас 2022 оны 3 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд банк, аж ахуйн нэгжүүдээс бүрдсэн 27 байгууллагын 100 гаруй мэргэжилтэнд төлбөрийн системийн талаарх сургалтыг зохион байгууллаа. Тус сургалт нь төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалт болон дэд бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотой мэдээ мэдээллийг хүргэх, оролцогч байгууллагуудын мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилготой юм. Тус сургалтаар “Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги-2026”, “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих шинэчлэгдсэн журам”, “Төлбөрийн картын зохицуулалт”, “ҮЦГТ-ийн төлбөрийн картын сүлжээний дүрэм”, картын гүйлгээний маргааны зохицуулалтанд орсон өөрчлөлт, дансны нэгдсэн дугаарлалт (IBAN) зэргийг дэлгэрэнгүй танилцууллаа. Мөн төлбөрийн системийн хяналт шалгалтын дагуу цаашид анхаарах асуудал, QR-ийн нэгдсэн зохицуулалт, их дүнтэй төлбөрийн системийн дүрэм болон автомат клиринг хаус системийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийн тухай тус тус танилцуулж, санал солилцов.

○ ТӨВ БАНК ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИЖ АЖИЛЛАНА

2022/03/30



Монголбанк 2022 оны 3 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд “Ногоон санхүүжилт-Бүс нутгийн чуулган”-нд хамтран зохион байгуулагчаар оролцож, панель хэлэлцүүлгүүдэд илтгэл тавилаа. Уг арга хэмжээний үеэр Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд хамтран “Ногоон санхүүжилтийн үндэсний замын зураг”-ийг батлав. Төрийн холбогдох байгууллагууд цаашид хамтран үндсэн 6 бүлэг, 25 дэд арга хэмжээг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд ногоон зээлийн багцын нийт зээлд эзлэх хувийг 10 хувьд хүргэх, хүлэмжийн хийг 22.7 хувиар бууруулах боломжийг бүрдүүлэх юм. Төв банкны зүгээс тогтвортой, ногоон санхүүжилтийг дэмжихэд анхаарал хандуулж буй бөгөөд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн баримт бичигт “Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх” хэмээн тусгаад буй.

○ ОРОН НУТГИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД САНХҮҮГИЙН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАГЧ БАГШ НАР БЭЛТГЭГДЛЭЭ

2022/04/07



Нийт аймгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг олгох сургагч багш бэлтгэх сургалтыг Монголбанк, Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтран зохион байгууллаа. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-ний дагуу бүс нутаг бүрт санхүүгийн боловсролын сургагч багшийг бэлтгэж байна. Ингэснээр санхүүгийн боловсролын сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, хөтөлбөрийн зорилтод бүлэг болох бичил жижиг, бизнес эрхлэгчдийн санхүүгийн сахилга бат болон санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлж, зөв хөрөнгө оруулалт хийж, бизнесээ өргөжүүлэх чадварт суралцуулах юм.

○ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН-2022”-Д МОНГОЛБАНК ОРОЛЦОВ

2022/04/07



4 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын эдийн засгийн чуулган-2022”-д Монголбанкнаас эдийн засгийн гадаад орчин, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, төв банкнаас авч хэрэгжүүлж буй бодлогын талаар илтгэл тавин, панел хэлэлцүүлгүүдэд оролцлоо. Чуулганы эхний өдөр “Шинэ сэргэлтийн бодлого - Эдийн засагт үүсч буй сорилт, боломж” сэдэвт нэгдсэн хуралдаанд Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн оролцож, дэлхийн эдийн засагт сөрөг шок, тодорхой бус байдал нэмэгдсэн энэ цаг үед валютын орох гарах урсгалын зөрүүн дээр түр зуурын хүндрэл үүсч байгаа ч удахгүй энэ бүхэн хэвийн байдалдаа орно гэсэн байр суурийг илэрхийлэв. Мөн “Гадаад орчны тодорхой бус байдал, үр дагавар - Үнэ, ханш, гадаад худалдаа, төлбөр тооцоо” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр эдийн засгийн гадаад орчинд үүссэн нөхцөл байдал, үр дагаврын талаар танилцуулгыг хийж, сорилтын үед Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын талаар тайлбар хийв. Төв банк макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, үндэсний мөнгөн тэмдэгт -төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг аваад буй.

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БОЛОН ТӨВ БАНКНЫ АРИЛЖААНЫ НЭГДСЭН СИСТЕМ (ҮЦТХНС)-ИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛАХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2022/04/08



Монголбанк нь Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (МҮЦАЭХ)-той хамтран 2022 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр тус холбооны гишүүдэд Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилттэй Монголбанкны “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төв банкны арилжааны нэгдсэн систем (ҮЦТХНС)-ийн талаарх танилцуулах уулзалтыг зохион байгууллаа. Тус уулзалтаар “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төв банкны арилжааны нэгдсэн систем (ҮЦТХНС)” болон “ҮЦТХНС-ийн интерфэйс холболт” зэргийг дэлгэрэнгүй танилцууллаа. Түүнчлэн, эдгээр системийг нэвтрүүлэх ажлын явц, техникийн гол функц болон шийдлүүд, Монгол Улсын нийт санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд Мэдээллийн технологийн системийн хувьд “нэг хэлээр, нэгдсэн ойлголтоор ярих” ач холбогдлыг зах зээлд оролцогч нарт ойлгуулах зорилготой байв.

ХАРИЛЦАГЧИД ЗӨВЛӨХ БАНКНЫ МЭРГЭЖИЛТНҮҮД БЭЛТГЭГДЛЭЭ

2022/04/11



Монголбанк, Монголын Банкны Холбоо, Шпаркассэ банкны Монгол дахь сан хамтран “Монгол Улсад Харилцагчид зөвлөх банкны мэргэжилтнийг сургах онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийн сургалтад 2022 онд 11 банкны 65 ажилтан хамрагдаж зөвлөх банкны мэргэжилтний батламж гадлаа. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх төв банкны бодлогын хүрээнд 2017 оноос хэрэгжиж байгаа энэхүү төсөл нь банкны салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж, банкны үндсэн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх зорилготой. Иргэд өөрсдийн хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг сонгоход санхүүгийн суурь мэдлэг чухал ач холбогдолтой байдаг. Иймд иргэдтэй шууд харилцах банкны ажилтныг нэн тэргүүнд чадавхжуулан, зөвлөгөө өгөх ур чадварт суралцуулах замаар олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг тус төсөл нь дэмжин ажиллаж байна.

Н.Ариунбат: БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ТОХИОЛДОЛД МОНГОЛБАНКНААС ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ШААРДЛАГАТАЙ

Монголбанкны Банкны бүтцийн
өөрчлөлт, бодлогын газрын захирал
Н.Ариунбаттай банкууд IPO гаргах үйл
ажиллагааны талаар ярилцлаа.



Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сард Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан. Банк нь хувьцаат компани хэлбэртэй байхаар тусгасан нь энэ хуулийн гол өөрчлөлтийн нэг болсон шүү дээ. Банкний хувьцаат компани хэлбэртэй байхаар зохицуулсан шалтгаан нь юу байв гэдгээс ярилцлагаа эхэлье.

Үүнийг ярихын тулд эхлээд манай улсын банкны салбарын сүүлийн 30 жилийн түүхийг ээрвэс сөхье. Монгол Улсад банкны хоёр шатлалт тогтолцоо үүсэж бий болсноос хойш нийт 35 банк байгуулагдсанаас 20 гаруй нь төлбөрийн чадваргүй болж, татан буугдсан. Ямар шалтгаанаас ийм нөхцөл байдал үүссэнийг судлахад банкны цөөн боловч том хувьцаа эзэмшигчид банкны удирдлагад зүй бусаар нөлөөлж, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргуулж байсан нь банкны зохистой засаглал алдагдах, цаашлаад үйл

ажиллагаа нь доголдох эрсдэлийг үүсгэж байсан байна. Тэгэхээр банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулж, банкны үйл ажиллагаанд олон нийтийн хараа хяналтыг нэмэгдүүлэх нь банкны засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг хэрэгжүүлэх арга зам нь банкнийг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах шаардлагатай болохыг тодорхойлсон.

Энэхүү нөхцөл шаардлагын хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хуулиар системд нөлөө бүхий 5 банк 2022 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн дотор IPO зарлах замаар нээлттэй хувьцаат компани болох шаардлагыг заасан бол бусад банкуудад нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани байх сонголтыг нээлттэй үлдээсэн. Банкны үйл ажиллагааг хувьцаат компани хэлбэрээр явуулах хуулийн өөрчлөлт нь цоо шинэ зохицуулалт биш юм. Өнгөрсөн

хугацаанд мөрдөгдөж байсан банкны тухай хуулиар банкнийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, эсвэл хувьцаат компани хэлбэртэй байх сонголттой байсан. Харин Банкны тухай хуулийн энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр банк нь зөвхөн хувьцаат компани хэлбэртэй байхаар зохицуулсан нь онцлог болж байна.

Тэгэхээр банкууд хувьцаат компани болсноор засаглал нь сайжирна гэж ойлгож болох уу?

Банкны тухай хуульд орсон өөр нэг томоохон өөрчлөлт нь банкны хувь эзэмшлийн төвлөрлийг 20 хувиар хязгаарлахаар заасан. Өөрөөр хэлбэл, нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийнхээ хамт тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй хэмжээний хувийг эзэмшихээр тусгасан. Банкууд энэ хуулийн хязгаарлалтыг 2023 онд багтаан хангасан байх ёстой. Банкны хувь эзэмшигчдийн төвлөрөл

буурч, олон тооны хувьцаа эзэмшигчдийн хараа хяналттай болно. Нөгөөтэйгүүр, банкууд нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй болж, хувьцаагаа олон нийтэд арилжаалдаг болсноор Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн биржийн зохицуулалт болоод банкны хувьцааг сонирхож буй хөрөнгө оруулагчид, иргэдийн хараа хяналтад давхар орно гэсэн үг юм. Энэ нь банкны үйл ажиллагаа олон нийтэд илүү ил тод болж, засаглал сайжрахад эерэг нөлөө үзүүлнэ.

Банкуудын хувьцаат компани болох ажил ямар шатандаа явж байгаа вэ?

Банкууд хуульд заасан хугацаанд хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах бэлтгэлийг ханган ажиллаж байна. Банкны тухай хуульд 2021 оны 1 дүгээр сард нэмэлт, өөрчлөлт орсны дараа банкныг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанк бусад зохицуулагч байгууллагуудтай хамтран шат дараатай авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, банкныг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, хувь эзэмшлийн төвлөрлөө бууруулах төлөвлөгөөг банкуудаас хүлээн авах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах түр журмыг Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой хамтран баталж, энэ журмын дагуу банкуудаас холбогдох төлөвлөгөөг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор хүлээн авч,

төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Мөн хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад Монголбанканд мэдэгдэх, зөвшөөрөл авах харилцааг зохицуулсан журмыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран баталсан. Ингэснээр эрх зүйн орчны хувьд хувьцаат компани болохтой холбоотой зохицуулалт бүрдсэн гэж үзэж болно. Банкуудын хувьд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн төлөвлөгөөнийхөө дагуу хувьцаат компани болох бэлтгэл ажлаа гүйцэтгэж, IPO зарлах, нээлттэй хувьцаат компани болох арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж эхлээд байна. Банкуудаас хамгийн түрүүнд Богд банк 2021 оны 12 дугаар сард хувьцааныхаа 20 хувийг олон нийтэд санал болгож, IPO амжилттай хэрэгжүүллээ.

Банкны хувьцаа хөрөнгийн биржээр арилжаалж буй бусад хувьцаанаас юугаараа ялгаатай вэ. Банкны хувьцаа худалдаж авч байгаа иргэд, хөрөнгө оруулагчид юуг анхаарах ёстой вэ?

Банк хувьцаагаа олон нийтэд санал болгож, хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болсноор хөрөнгийн зах зээл дээр бүтээгдэхүүний төрөл зүйл, хөрөнгө оруулалтын сонголт нэмэгдэх эерэг нөлөөллийг бий болгоно. Банкуудын хувьд үйл ажиллагаагаа олон жил тогтвортой явуулж буй

туршлагатай, банкны тухай хууль тогтоомжоор тогтоосон шалгуур шаардлагыг хангаж ажилладаг, Монголбанкнаас үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг зэрэг нь урт хугацаанд тогтвортой хөрөнгө оруулалт хийх сонирхолтой хөрөнгө оруулагчдын шийдвэрт магадгүй давуу тал байж болох юм. Банкны хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалах үйл явц бусад хувьцаат компанийн хувьцаа, үнэт цаасны арилжаатай ижил зарчмаар явагдана. Харин банкны нийт гаргасан хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаар эсвэл холбогдох этгээдийн хамт худалдан авч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох тохиолдолд банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох хүсэлтээ банкаар дамжуулан Монголбанканд хүргүүлж, зөвшөөрөл авах шаардлагатай. Жижиг хувьцаа эзэмшигчид, цөөн тоогоор банкны хувьцаа худалдан авч буй иргэдэд энэхүү шаардлага нь хамаарахгүй боловч том дүнгээр хувьцаа эзэмшиж, банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох харилцагчид Монголбанкнаас зөвшөөрөл авахдаа ямар материал бүрдүүлэх талаар тухайн банкнаасаа тодруулах, эсвэл Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны А-282/282 дугаар тушаалаар батлагдсан "Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-аас үзэхийг зөвлөө.

Ярилцсанд баярлалаа.



БАНКНЫ ХУВЬЦААГ ХУДАЛДАЖ АВАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Банк нь эдийн засгийн тогтвортой байдал, тэнцвэртэй хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг тул түүний зохистой засаглалыг хамгаалах үүднээс Монголбанк банкны хувьцааг эзэмших, тэр дундаа банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох зөвшөөрлийг олгодог.

Хөрөнгийн биржийн арилжаагаар үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх этгээдээр зуучлуулан банкны хувьцааг худалдаж авах аливаа этгээд доорх зохицуулалтын талаар судалж үзэх нь зүйтэй. (Банкны тухай хуулийн 36 дугаар зүйл, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны А-262/262 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-аас холбогдох зохицуулалтыг үзнэ үү).



Банкны засаглалыг бэхжүүлэх нь тус салбарт хийгдэж буй шинэчлэлтийн томоохон зорилт юм. Энэ хүрээнд хувьцаа эзэмшлийн төвлөрөлийг бууруулж, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх зорилгоор Банкны тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани болох талаар мэргэжилтнүүд юу хэлэв?



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ҮНЭТ ЦААСНЫ
ГАЗРЫН АХЛАХ РЕФЕРЕНТ
Н.ЭНХБААТАР

2021 он гарснаар дотоодын хөрөнгийн зах зээлд банкны IPO /Богд банк/, компанийн бонд, биржээр арилжаалагддаг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан зэрэг шинэ бүтээгдэхүүний тоо өсөхийн зэрэгцээ хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл сэргэж, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын үзүүлэлт нэмэгдэх болсон бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар зах зээлийн үнэлгээ 5.98 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 97.47 хувиар өссөн бол үнэт цаасны арилжааны хэмжээ 1.41 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.64 дахин өссөн. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээлд гарсан энэхүү өндөр өсөлт, амжилт нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, сонирхол нэмэгдэх, дотоодын аж ахуй нэгжээс шинэ бүтээгдэхүүн гаргаж, олон нийтээс санхүүжилт татах нь ихсэж байгааг харуулж байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийн идэвхжил, өндөр өсөлттэй энэ цаг үетэй банкны салбарын реформ давхцаж байгаа нь банкны системд нөлөө бүхий банкуудын IPO амжилттай болох урьдач нөхцөл бүрдэн цаашид хөрөнгийн зах зээлийн өсөлтийг хурдасгаж, хөгжлийг нэмэгдүүлнэ гэсэн өөдрөг хүлээлтийг бий болгож байна.

Тодруулбал, банкны системд нөлөө бүхий бус банк болох “Богд банк” ХХК-иас 2021 онд дотоодын зах зээлд IPO хийж, нийт 31.75 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүлээд байгаа нь банкны салбарын реформын хүрээнд эхнээсээ банкуудын нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагаа амжилттай болж байгааг харуулж байна. Мөн Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанканд ирүүлсэн банкуудын төлөвлөгөөний хүрээнд банкны системд нөлөө бүхий 5 банкнаас IPO хийх замаар хөрөнгийн зах зээл дээрээс нийт 633 орчим тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх урьдчилсан төсөөлөл байгаа ба эдгээр системийн банкууд IPO хийх ажиллагааг амжилттай хэрэгжүүлснээр зах зээлийн үнэлгээ 5.6 орчим их наяд төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түүхэнд анх удаа зах зээлийн үнэлгээ 10 их наяд төгрөгт хүрэх чухал ач холбогдолтой үйл явдал

болно. Эцэст нь хэлэхэд, нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргаж, хөрөнгийн зах зээл дээрээс бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлэх замаар нээлттэй хувьцаат компани болох нь тухайн үнэт цаас гаргагч, түүнтэй гэрээ байгуулсан андеррайтерийн компани, мэргэжлийн оролцогч байгуулагуудын нягт хамтын ажиллагааны үр дүн, хөрөнгө оруулалт хийх сонирхлоо илэрхийлэн урьдчилан гэрээ, хэлэлцээр хийсэн стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчид болоод олон нийтээс татан төвлөрүүлэх санхүүжилтийн хэмжээ, зах зээлийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлсээс хамаарах боломжтой байдгийг онцолмоор байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖИЙН ЗАХИРАЛ
Х.АЛТАЙ

Банкуудыг олон нийтэд нээлттэй болгох нь томоохон шинэчлэлийн ажил юм. Системийн томоохон банкууд сүүлийн 30 жил Монгол Улсдаа үйл ажиллагаагаа эрхэлсэн хамгийн том хувийн аж ахуй нэгжүүд. Үүн дээр Төрийн банк нэмэгдэж орж ирнэ. Төрийн банкны хувьд төрийн өмчит учраас Засгийн газар, УИХ-аас холбогдох шийдвэр гарсны дараа олон нийтэд нээлттэй болох ажил нь эхэлнэ. Бид банкуудын хувьцааг бүртгэж, арилжаалах хуулийн үүрэгтэй, дэд бүтцийн байгууллага. Системийн топ банкууд дэлхийн дөрвөн том аудитын байгууллагаар аудит хийлгэдэг, жил бүр ашигтай ажилладаг, хүн бүр энэ банкуудын харилцагч гэдэг утгаараа хөрөнгийн зах зээлд том түлхэц болно. Тиймээс зөвхөн дотоодын зах зээлийн багтаамжаар IPO хийхээсээ илүү гаднын хөрөнгө оруулагчийг татахад тодорхой ажлууд хийнэ.

Монголын хөрөнгийн биржээс банкуудыг олон нийтэд нээлттэй болгох хүрээнд үнэт цаасны бүртгэлийн хураамжийг 10-75 хувиар бууруулна. Мөн үнэт цаас гаргагчийн төлөх анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийг тэглэх, арилжааны шимтгэл тооцооллыг олон улсын стандартад нийцүүлэх зэргийг журамдаа тусгаж, ТУЗ-өөрөө батлуулахаар ажиллаж байна. Түүнчлэн хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох процессыг хөнгөвчлөхөд анхааран ажилласан. Тухайлбал, хөрөнгө оруулагчид 100 хувь цахимаар оролцож, банкны хувьцааг гар утаснаасаа онлайн хэлбэрээр авах боломж бүрдсэн гэж хэлж болно. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.2 их наяд орчим байгаа. Банкуудын IPO хийснээр энэ үзүүлэлт хоёр дахин нэмэгдэж, 10 их наядад хүрэх боломжтой гэж үзэж байна. Одоо бид ДНБ-ий 15 орчим хувьтай тэнцэхүйц үнэлгээтэй байна. Тэгэхээр бид цаашдаа ДНБ-ий 30 хувьтай тэнцэх хэмжээний үнэлгээтэй болно гэсэн үг. Энэ бол мэдээж маш том үсрэлт болно. Цаашдаа энэ банкууд олон харилцагчтай учир өөрийн үйлчлүүлдэг банкны хувьцааг худалдаж авна. Тэгээд хувьцаагаа хоёрдагч зах зээл дээр арилжаална. Ингээд арилжааны хувьд ч гэсэн тэлнэ.



МАНДАЛ САНХҮҮГИЙН
НЭГДЛИЙН ТУЗ-ЫН ДАРГА
Ө.ГАНЗОРИГ

Монголд 2 шатлалт банкны тогтолцоо үүсээд хэдийнээ 30 гаруй жил боллоо. Энэ хугацаанд маш олон арилжааны банк байгуулагдаж, татан буугдаж, дампуурлаа зарласан үйл явдал болсон. Банкны салбар дахь муу жишээг дурдъя гэвэл Анод банк, Зоос банк, Капитал банк зэргийг нэрлэж болно. Эдгээр банк дампуурсан хамгийн гол шалтгаан нь нэг хүнээс хамаарсан байдал буюу хувь эзэмшлийн төвлөрөл мөн. Тэгвэл одоо бид системийн нөлөө бүхий гэгддэг 5 банкны хувьцаа эзэмшигч болох боломж бүрдээд байна. Банкнууд нээлттэй болох нь засаглалыг шууд шинэ шатанд аваачих буюу хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурна, хувьцаа эзэмшигчдийн төрөлжилт нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, харилцан хяналтын систем нэвтэрч, нэг том хувьцаа эзэмшигчээс хамаарах, шийдвэр гаргалт гажуудалтай байх, том хувьцаа эзэмшигчийн гүйцэтгэх удирдлага дахь нөлөөлөл зэрэг нь багасна. Ингэснээр банкнууд санхүү болон бизнесийн үйл ажиллагааны эдийн засгийн бодит үр ашигт байдлаа нэмэгдүүлэх боломж гарна гэж харж байна. Үүнээс хадгаламж эзэмшигч, хувьцаа эзэмшигчид хожих бололцоо бүрдэх юм. Хөрөнгө оруулагчдын хувьд ямар банканд хөрөнгө оруулахаа олон талаас нь харж байж сонгох шаардлагатай.

Банкны IPO-д оролцохоор бэлтгэж буй хөрөнгө оруулагчдад өөр нэг давуу тал байгаа нь банкнууд хаалттай компани хэлбэрээр байхдаа ч санхүү, бизнесийн үйл ажиллагааныхаа зарим хэсгийг нийтэд нээлттэй, ил тод байдлаар мэдээлдэгт оршино. Жишээлбэл, аудитын тайлан, улирал тутмын санхүүгийн гүйцэтгэлээ тайлагнадаг, шинэ бүтээгдэхүүнээ танилцуулдаг гэх мэт. Мэдээж ирээдүйд өндөр өсөлттэй ажиллах боломжтой банкандаа хөрөнгө оруулж байж л хөрөнгө оруулагчдын өгөөж нэмэгдэх боломжтой шүү дээ. Арилжааны банкнууд санхүүгийн систем, цаашлаад улс оронд төлбөр тооцооны талбар, зээлдэгч хадгаламж эзэмшигчдийг холбох гүүр, бизнес эрхлэгчдийг дэмжих томоохон хөшүүрэг болж байдаг. Банкнууд, ялангуяа системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани болж байгаа нь илүү нээлттэй, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхээс гадна, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь төрөлжиж, санхүүгийн бодлого, нэр хүнд нь сайжирна. Мөн гадаадын хөрөнгө оруулагчдын банкнуудад хүлээлгэх итгэл нэмэгдэж, илүү бага өртгөөр, олон талын эх үүсвэрээс санхүүжих бололцоо бий болох ач холбогдолтой. Эргээд банкнуудын хямд эх үүсвэрээр санхүүжсэнээр иргэд, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа богино хугацаанд тэлэх боломжтой болж ирнэ.



Бурханы Башны Шүтээн Зургийн Урлал

Тинка гэдэг нь дэлгэмэл буюу хүйлмал зураг гэсэн утгатай түвэд үг юм. Монголчууд танка буюу бурхан дүрслэлийн энэхүү төрлийг “Шүтээн зураг, бурхан зураг” хэмээн нэрлэх боловч бас хар дэвсгэрт нагтан, улаан дэвсгэрт мартан, цагаан дэвсгэрт гартан, алтан шар дэвсгэрт сэтрэн танка гэж түвэд нэрилээр тэмдэглэсэн нь бий. Харин Түвэдэд танка зураг нь XIV зуунаас хойш хятадын уран зургаас олон зүйлийг өөртөө шингээн хөгжсөөр XVIII зуунд оргил үедээ хүрсэн юм. XVII-XVIII зуунд Монголд бурханы шашны хүрэл цутгамал, баримлын урлаг тэргүүлэх аястай хөгжиж байсан бол, XVIII зууны сүүлчээр бурхан дүрслэлийн танка зургийн төрөл түүнтэй эн зэрэгцэн хөгжих болсон юм. XX

зууны эхэн гэхэд шүтээн зургийн хөгжил оргилдоо хүрч, олон лам нар өөрсдийн бүтээлээрээ ялгаран нэрд гарчээ. Тухайн үед Хүрээ нь шашны төв болохын хувьд бурхан шүтээн болон шашны хэрэгсэл урлах цогц сургалт явуулснаар торгон зураг хөгжих гол суурь болжээ. Шүтээн зургийн урлал нь хар, улаан, цагаан, шаргал өнгөт дэвсгэр дээр шороон ба есөн эрдэнийн будгаар бурхан дүрслэлийн онол буюу лагидны тусгайлсан тиг хэмжээ, өнгө дүрслэл, мутар болоод тэргүүн, барьц гишгэдэл, өмсгөл, чимэг зүүлт, тахил бэлгэдлийн дагуу бурханыг бүтээх бөгөөд ихэвчлэн догшин сахиус бурханыг хар болон улаан дэвсгэр дээр, амгалан дүрт бурханыг алтлаг шар, цагаан өнгийн дэвсгэр дээр дүрсэлдэг байна. Мөн шүтээн зургийн нэгэн төрөлд загал зураг орох бөгөөд “Загал” хэмээх үг нь алга дарам, нүүрний чинээ гэсэн түвэд үг бөгөөд (Алга дарам нь монгол уламжлалт гарын хэмжээсээр 10 см болно) танка буюу шүтээн зургийн адил бурхан дүрслэлийн онол, тиг хэмжээг баримтлан, хар, хөх, цагаан, алтлаг дэвсгэр дээр шороон болон есөн эрдэнийн будгаар дүрслэх нарийн ур чадвар шаардсан урлаг болно. Загал зургийг анхлан сүм хийдэд зан үйлийн зорилгоор зурж хэрэглэдэг байжээ. Тухайлбал сүм хийд барихын өмнө тухайн газарт загал зургийг жижиг модонд жаазлан хамгаалагч сахиус болгон хэрэглэх болсны адилаар лам нар өвчтөй хүн болон үр жимсгүй мод зэргийг буг чөтгөрийн хүчнээс зайлуулах зорилгоор сахиус бурханы зургийг жаазлан хэрэглэх болсноос дэлгэрэн түгэн гарчээ. Ийнхүү Загал зургийг хүзүү болон мөрний гуу саванд хийн, хамгаалагч сахиус болгон хэрэглэх болжээ.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН ХУРЛААС

ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТ, ХАРИУЛТ

Оросын Холбооны Улсын томоохон банкуудыг Европийн Холбоо олон улсын санхүүгийн систем болох SWIFT-ээс хассан нь Монгол улсын арилжааны банкуудад ямар нөлөө байгаа вэ?

Европийн Холбоо болон бусад улс орнууд SWIFT системээс Оросын Холбооны Улсын томоохон банкуудыг гаргаж, хориг тависан нь Монгол улсын арилжааны банкууд ОХУ-ын банкуудтай төлбөр тооцоо хийж гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байгаа хэдий ч хориг тавигдаагүй арилжааны банкуудаар дамжуулан гадаад төлбөр тооцоог хийж гүйцэтгэж байна. Бусад гадаадын улс орны банкуудтай гадаад гүйлгээ хэвийн хийгдэж байна.

Үүсээд байгаа нөхцөл байдлын улмаас Монголбанк арилжааны банкуудад валютаар гадаад төлбөр тооцоо хийж гүйцэтгэхэд хязгаарлалт тогтоох чиглэл өгсөн үү?

Монголбанк арилжааны банкуудын валютын арилжаанд хязгаарлалт тогтоосон гэх мэдээ нь ташаа мэдээлэл юм. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 32.2 дугаар зүйлд Монголбанк хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа банкны дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй гэж заасан байдаг. Банкууд валют арилжаанд хязгаарлалт тавьж байгаа нь зах зээлд валютын нийлүүлэлт хомс байгаагаас шалтгаалан банкуудын бие даан гаргасан шийдвэр юм.

Арилжааны банкууд валютын арилжаанд яагаад хязгаарлалт тогтоох болов?

Цаг үеийн нөхцөл байдал тогтворгүй, гадаад зах зээлийн тодорхой бус байдал үргэлжилсэн хэвээр байна. Арилжааны банк нь валютын захын эрэлт хэрэгцээнд үндэслэн валют худалдах, худалдан авах өөрийн ханшийг тогтоодог бөгөөд зарласан валютын ханш, тогтоосон хязгаарлалт нь эдийн

засгийн нөхцөл байдал, дотоодын валютын зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс шууд хамаардаг. Монголбанк гадаад валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гараг бүр зохион байгуулж дуудлага худалдаа болон цахим талбараар дамжуулан дотоодын валютын зах зээлд гадаад валютыг нийлүүлж байна.

Төгрөгийн ам.доллартай тэнцэх ханш 2 жил орчим тогтвортой хадгалагдаж байгаад сүүлийн өдрүүдэд сулраад байна. Үүнд юу нөлөөлж байна вэ?

Цар тахлаас шалтгаалан бараа бүтээгдэхүүний импорт бага байсан, нөгөө талдаа экспортын орлого өндөр байсан нь ГВАН-ийг өсгөх, ханшийг тогтвортой байх боломжийг бүрдүүлсэн.

2021 оны 2 дугаар хагасаас эхлэн гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж, экспортлох бүтээгдэхүүний тоо хэмжээ буурснаас төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч улмаар төгрөгийн ханш сулрах дарамт өсөөд байна.

Монголбанк валютын зах зээлд ямар зарчмаар оролцдог вэ. Монгол Улс ханшийн ямар дэглэмийг мөрддөг вэ?

Монгол улс зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмийг баримталдаг. Төв банкнаас зах зээлд богино хугацааны шинжтэй огцом хэлбэлзэл бий болохоос сэргийлж гадаад валютын захад оролцдог.

Одоогийн нөхцөлд гадаад худалдаа, төлбөр тооцооны хэвийн үеийн нөхцөл байдал алдагдаж, гадаад валютын орлого тасалдаад байгаа тул төв банкнаас бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тасалдал үүсэхээс сэргийлэх зорилгоор гадаад худалдааны төлбөр тооцоонд шаардлагатай гадаад валютыг зах зээлд нийлүүлэхэд анхаарч байна.

Албан ханш болон түүний хэрэглээ нь юу вэ?

Монголбанкнаас зарласан албан ханш нь Валютын зохицуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу гадаад валютаар олсон орлого, импортын барааны хилийн үнийг төгрөгт шилжүүлэн гаалийн болон бусад татвар ногдуулах хэмжээг тодорхойлох, гадаад валютаар илэрхийлэгдсэн аливаа хөрөнгө, эх үүсвэрийг нягтлан бодох бүртгэлд төгрөгөөр илэрхийлж тусгахад мөрдлөг болгон ашигладаг.

Гадаад валютын ханш хэрхэн тогтдог вэ?

Монголбанк Валютын зохицуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Гадаад валютын арилжааны мэдээ гаргах журам”, “Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тооцож, зарлах заавар”-ыг тус тус мөрдлөг болгон тухайн өдрийн албан ханшийг тооцон олон нийтэд зарладаг. Ингэхдээ банкуудын гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн ам.долларын арилжааны жигнэсэн дундаж ханшаар тухайн өдрийн төгрөгийн ам.доллартой харьцах албан ханшийг тооцож зарладаг.

Оросын Холбооны Улсын рублийн ханш яагаад зөрүүтэй байгаа вэ?

ОХУ-ын рублийн хувьд Монголбанкнаас тухайн өдөр тооцсон ам.долларын ханшийг Ройтерс терминалаас татсан кросс ханшид хуваан тооцож байна. Тиймээс төгрөгийн рубльтэй харьцах албан ханшийн хөдөлгөөн нь дотоодын валютын зах зээл дээрх төгрөг ам.долларын ханшийн хөдөлгөөн болон олон улсын зах зээл дээрх рубль ам.долларын ханшийн хөдөлгөөнөөс хамаарч байна.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

2022 оны 3 дугаар сар

ИНФЛЯЦ




2022 оны 3 дугаар сард бодлогын хүүг 2.5 нэгж хувиар өсгөж 9.0 хувьд хүргэв.



Эх сурвалж: Монголбанк

2022 оны 3 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд инфляц 14.4 хувьтай гарав.



ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ



Мах, махан бүтээгдэхүүн 15.9%

УЛААНБААТАР ХОТ



Сүү, сүүн бүтээгдэхүүн 7.9%



Төрөл бүрийн өөх, тос 41.3%



Хүнсний ногоо 44.0%



Талх, гурил, будаа 16.3%



Сахар, жимсний чанамал, чихэр, шоколад 14.1%


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1


M2 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ



M2 мөнгөний нийлүүлэлт 2022 оны 3 дугаар сард 26.5 их наяд ₮ хүрч, өмнөх оны мөн үеэс 4.2% -иар өсөв.



M2-ийн өсөлт байршуулалт талаас



M2-ийн өсөлт эх үүсвэр талаас




Эх сурвалж: Монголбанк

2

ЗЭЭЛ



2022 оны 3 дугаар сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 25.2%-иар өсч 21.9 их наяд төгрөгт хүрэв.




Хувийн байгууллага

Иргэд

26.2%

27.2%

2022 оны 3 дугаар сарын байдлаар чанаргүй зээл 9.7%-тай байна.




Зээлийн жилийн өсөлт, салбарын ангиллаар




Эх сурвалж: Монголбанк

3

Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл **5,800.3** тэрбум төгрөгт хүрэв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Зээлдэгчдийн тоо



104,784

Үүнээс:




74%



26%

Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү
(*хөнөөлөлттэй зээл оруулснаар)



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийн динамик, сая ам.доллар



МУ-ын төлбөрийн тэнцэл 2022 оны эхний 3 сарын урьдчилсан байдлаар **953.6** сая ам.долларын алдагдалтай гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц

Бариа	Анхдагч орлого	Хөрөнгийн данс
-\$135.1 сая	-\$579.7 сая	\$27.2 сая
Үйлчилгээ	Хоёрдогч орлого	
-\$379.0 сая	\$121.4 сая	

Санхүүгийн дансны бүтэц

Шууд хөрөнгө оруулалт	Багцын хөрөнгө оруулалт
\$758.8 сая	-\$72.4 сая
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	Бусад хөрөнгө оруулалт
\$6.6 сая	-\$456.8 сая

Эх сурвалж: Монголбанк

ЭДИЙН ЗАСАГТ МӨНГӨ ХЭРХЭН БИЙ БОЛДОГ ВЭ?¹

Michael McLeay², Amar Radia³,
Ryland Thomas⁴

(Английн төв банкны мөнгөний
бодлогын шинжилгээний зөвлөл)

Орчуулсан: Б.Гэрэлмаа⁵, Д.Ургамал⁶,
А.Анударь⁷

Орчин үеийн эдийн засагт ихэнх мөнгө банкны харилцах, хадгаламжийн хэлбэрээр байршдаг. Гэхдээ банкны харилцах, хадгаламж хэрхэн бий болдог талаар нэлээдгүй ташаа ойлголт байдаг билээ. Арилжааны банк зээл олгох нь эдгээр харилцах, хадгаламж бий болох үндсэн зам юм. **Банк зээл олгомогц энэ нь зээлдэгчийн банкан дахь харилцах дансны үлдэгдлийг нэмэгдүүлж, шинэ мөнгө үүсдэг.**

Бодит байдал дээр хэрхэн мөнгө бий болж байгаа нь зарим эдийн засгийн номнууд дээр тайлбарласнаас ялгаатай байдаг.

- Банк өрхүүдээс хадгаламж татаж тус эх үүсвэрээ зээлдүүлэх бус харин банк зээл олгосноор харилцах дансыг нэмэгдүүлдэг.
- Энгийн үед, төв банк эргэлтэнд буй мөнгөний хэмжээг тогтоодоггүй, мөн төв банкин дахь нөөц мөнгө зээл, хадгаламж болж үржигддэггүй байна.

Хэдийгээр арилжааны банк зээл олгох замаар мөнгө бий болгож байгаа боловч тэд хязгааргүйгээр мөнгө бий болгох боломжгүй. Өндөр өрсөлдөөн дунд банк ажиллаж байгаа нь банкны олгох зээлийн хэмжээнд хязгаарлалт болдог. Мөн нөгөө талаас санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр банкны олгох зээлийн хэмжээ

хязгаарлагддаг. Өрх, ААНБ-ын хувьд зээл олголтоор бий болсон шинэ мөнгөний хэмжээнд өөрсдийн үйл хөдлөлөөр нөлөөлөх боломжтой. Жишээлбэл, зээлдэгч зээл авмагцаа уг мөнгөөр хуучин зээлээ хаасан тохиолдолд эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээ өөрчлөгдөхгүй юм.

Мөнгөний бодлого мөнгө бий болох үйл явцад эцсийн хязгаарлалт болох хэлбэрээр ажилладаг. Тухайлбал, ихэнх төв банк эдийн засагт бий болж буй мөнгөний хэмжээ нам дор инфляцын түвшинтэй нийцтэй байхыг зорьдог. Хэвийн үед инфляцыг онилдог төв банк нөөц мөнгөний хүүг тогтоох замаар мөнгөний бодлогоо хэрэгжүүлдэг нь зээлийн хүүнээс эхлээд эдийн засаг дахь бусад хүүнд нөлөөлдөг.

Онцгой нөхцөлд, төв банкны бодлогын хүү хамгийн доод түвшинд байгаа хэдий ч, шинээр бий болж буй мөнгөний хэмжээ болон эдийн засаг дахь нийт хэрэглээ Төв банкны мөнгөний бодлогын зорилтот түвшнээс бага байх тохиолдол байдаг. Энэ үед төв банк зах зээлээс тодорхой төрлийн санхүүгийн хөрөнгийг худалдан авах үйл ажиллагаа (QE) хэрэгжүүлж болдог. QE нь ихэвчлэн банкнаас бусад санхүүгийн байгууллага⁸-аас санхүүгийн хөрөнгийг шууд худалдан авах замаар эдийн

1 Зохиогчид болон Английн төв банкны албан ёсны зөвшөөрөлтэйгөөр орчууллаа.

2 Английн төв банкны Мөнгөний бодлогын зөвлөл (Bank of England, Monetary Policy Advisor)

3 Английн төв банкны Банкны стресс тестийн туршилтын стратегийн хэлтсийн стратеги, судалгааны багийн менежер (Bank of England, Strategy and Research team, Stress Testing Strategy Division, Manager)

4 Английн төв банкны Мөнгөний үнэлгээ болон стратегийн хэлтсийн ахлах эдийн засагч (Bank of England, Monetary Assessment and Strategy Division, Senior Economist)

5 Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын ахлах эдийн засагч.

Цахим шуудан: gerelmaa@mongolbank.mn

6 Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын эдийн засагч.

Цахим шуудан: d.urgamal@mongolbank.mn

7 Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын эдийн засагч.

Цахим шуудан: anudari.a@mongolbank.mn

⁸ Банкнаас бусад бүх төрлийн санхүүгийн байгууллагуудыг хамруулсан. Тухайлбал, тэтгэврийн сан, даатгалын байгууллага гэх мэт (орч.)

засаг дахь мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх үйл ажиллагаа юм.

QE нь эхэндээ санхүүгийн хөрөнгөө худалдсан банкнаас бусад санхүүгийн байгууллагын банкин дахь харилцах, хадгаламжийг нэмэгдүүлнэ. Тэдгээр банкнаас бусад санхүүгийн байгууллага нь өөрсдийн хөрөнгө оруулалтын багцын өгөөжийг сайжруулах зорилгоор өндөр өгөөжтэй хөрөнгийг худалдаж авах бөгөөд энэ нь тэдгээр хөрөнгийн үнийг өсөхөд нөлөөлж, улмаар эдийн засаг дахь хэрэглээг нэмэгдүүлдэг.

Дээрх үйл ажиллагааны дам нөлөөгөөр төв банкны нөөц мөнгө⁹ шинээр бий болдог. Гэхдээ ийнхүү шинээр нөөц мөнгө бий болох нь мөнгөний бодлогын шилжих механизмд тийм ч чухал нөлөө үзүүлдэггүй. Энэ өгүүлэлээр энгийн үед шинэ нөөц мөнгө нь зээл, хадгаламж болж үржигддэггүй талаар, мөн энэ нь яагаад банкинд өгсөн “үнэгүй хоол” биш болохыг тус тус тайлбарлана (*Монгол Улсын хувьд мөнгөний нийлүүлэлтийг хэрхэн тооцоолж буйг Хавсралтын (2)-оос харна уу*).

Энэхүү өгүүлэлд мөнгө бий болох үйл явцын тухай доорх түгээмэл хоёр ташаа ойлголтыг тайлбарлах юм. Нэгдүгээрт, орчин үеийн эдийн засагт арилжааны банк зээл олгох замаар ихэнх мөнгийг хэрхэн бий болгож байгааг¹⁰; хоёрдугаарт,

банкны системийн мөнгө бий болгох хязгаар болон зээл, мөнгөний өсөлт нь эдийн засгийн мөнгө, санхүүгийн тогтвортой байдалтай нийцтэй эсэхийг хянадаг төв банкны бодлогын талаар танилцуулна¹¹. Хамгийн сүүлийн хэсэгт QE хэрэгжүүлэх үеийн мөнгөний шилжих механизмд мөнгөний гүйцэтгэх үүргийн талаар, QE болон мөнгө бий болох хамаарлын талаар зарим оньсогыг тайлна.

Мөнгө бий болохтой холбоотой ташаа ойлголтууд

Олон нийтийн эзэмшиж буй мөнгөний ихэнх хэсэг нь банкин дахь харилцах, хадгаламж хэлбэрээр байршдаг. Гэхдээ банкны харилцах, хадгаламж хэрхэн бүрддэг талаар ташаа ойлголтууд бий. **Эхний ташаа ойлголт нь банк зөвхөн хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг зээлдэгч нарт зээлдүүлж санхүүгийн зуучлал хийдэг гэсэн ойлголт юм.** Энэхүү үзлээр өрхүүдийн хадгалах шийдвэрээс хадгаламж бий болдог бөгөөд банк эдгээр хадгаламжийг хөрөнгө оруулалт хүссэн компанид, эсвэл орон сууц худалдан авахыг хүссэн хувь хүнд зээлдүүлдэг.

Үнэн хэрэгтээ, өрхүүд банк дахь харилцах, хадгаламжаа нэмэгдүүлэх сонголтыг хийх үед, эдгээр харилцах, хадгаламж нь компаниудад бараа, үйлчилгээний төлбөр болж

очих байсан мөнгө байдаг. Энэхүү хадгалах шийдвэр нь дангаараа хадгаламжийг нэмэгдүүлэх, эсвэл банкны зээлдүүлэх боломжтой нөөцийг нэмэгдүүлдэггүй. Түүнчлэн банкыг зөвхөн санхүүгийн зуучлагч мэтээр харах нь орчин үеийн эдийн засагт банкыг харилцах, хадгаламжийг бий болгогч нар гэдгийг үл ойшоосон хэрэг болно. Энэ өгүүлэлээр харилцах, хадгаламжийг зээл болгож гаргах биш, зээл гаргах нь харилцах, хадгаламж бий болгох буюу эдийн засгийн онолын номуудад ихэвчлэн тайлбарлагддаг дарааллын эсрэг болохыг тайлбарлана.¹²

Өөр нэг ташаа ойлголт бол төв банк нь өөрийн нөөцийн хэмжээг хянаснаар эдийн засаг дахь зээл, хадгаламжийн хэмжээг тодорхойлдог гэх “мөнгөний үржүүлэгчийн” үзэл юм. Энэхүү үзлээр, төв банк нь мөнгөний бодлогоо банкуудын төв банк дахь нөөцийн хэмжээг тогтоосноор хэрэгжүүлдэг. Мөн мөнгөний нийлүүлэлт, нөөц мөнгө¹³-ний харьцаа тогтмол гэж үзээд эдгээр нөөцүүд нь үржигдсээр илүү их өөрчлөлтийг банкуудын зээл, хадгаламжид бий болгодог гэж үздэг. Энэхүү онол биелэхийн тулд нөөцийн хэмжээ нь зээлийн хязгаарлалт болох бөгөөд төв банк нөөцийг шууд тодорхойлох ёстой болдог. Мөнгөний үржүүлэгчийн онол

⁹ Орч. Central bank reserves — Төв банкны нөөц мөнгө

¹⁰ Энэ өгүүллийн турш банк, арилжааны

банк гэрсэн нэр томъёогоор банк болон банкны үйлчилгээ үзүүлдэг хувийн байгууллагыг хамрууллаа.

¹¹ www.youtube.com/watch?v=CvRAqR2pAgw

¹² Мөнгөний эндоген шинж чанарыг орхигдуулсан олон өгүүлэлүүд бий. Жишээлбэл, Moore [35], Howells [25] and Palley [36].

¹³ Орч. base money — нөөц мөнгө

нь мөнгө болон банкны талаар эдийн засгийн сурах бичгүүдэд танилцуулах арга боловч, бодит байдал дээр энэ нь мөнгө хэрхэн бүтдэг талаарх буруу ойлголтыг бий болгож байна. Өнөө цагт ихэнх төв банкууд нөөцийн хэмжээг хянахаас илүүтэйгээр нөөцийн үнийг буюу бодлогын хүүг тогтоох замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байна.

Бодит байдал дээр, нөөцийн хэмжээг Төв банк тогтоодоггүй бөгөөд нөөцийн хэмжээ нь зээлийн хязгаарлалт болдоггүй. Хадгаламж, зээлийн хоорондын хамааралтай адилаар, нөөц болон зээлийн хамаарал нь зарим эдийн засгийн сурах бичгүүдэд эсрэгээрээ тайлбарлагддаг. Банкууд эхлээд ашиг олох боломжтой зээлийн судалгаанд үндэслэн зээл олгох шийдвэрээ гаргана. Банк зээл олгох эсэх энэхүү шийдвэрт төв банкны бодлогын хүү томоохон нөлөө үзүүлдэг. Үүнийг харгалзан банк зээл олгосноор банкны системд хэр их хэмжээний харилцах, хадгаламж бий болохыг банкууд тодорхойлно. Энэхүү банкны харилцах, хадгаламжийн хэмжээ буцаад банкууд хэр их хэмжээний нөөцийг төв банкинд байршуулах (банкны харилцагч харилцах данснаасаа мөнгө татах, банк хооронд төлбөр тооцоо хийх, банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах гэх мэт зориулалтаар)-ад нөлөөлөх бөгөөд хэвийн үед тус нөөцийг мөнгөний эрэлттэй нь нийцүүлэн

төв банк хангаж байдаг. Энэ талаар дэлгэрэнгүй дараагийн хэсгүүдэд тайлбарлах болно.

Бодит байдал дээр мөнгө хэрхэн бий болдог вэ?

Мөнгөний нийлүүлэлт гэдэг нь эдийн засагт ААНБ, өрхүүдийн эзэмшиж буй нийт мөнгөний хэмжээ юм. Мөнгөний нийлүүлэлт нь банкны харилцах, хадгаламж буюу өрх, ААНБ-уудын өмнө хүлээж буй үүрэг бөгөөд бэлэн мөнгө нь төв банкны өрийн бичиг¹⁴,¹⁵ болдог. Энэхүү хоёр төрлийн мөнгөний нийлүүлэлтэнд банкны харилцах, хадгаламж дийлэнх хувийг буюу эдийн засгийн эргэлт дэх нийт мөнгөний 97 хувийг эзэлдэг.¹⁶ **Мөн орчин үеийн эдийн засагт, эдгээр банкны харилцах, хадгаламжуудыг арилжааны банкууд өөрсдөө бий болгодог байна.**

Арилжааны банкууд зээл олгох замаар банкны харилцах, хадгаламж хэлбэрээр мөнгийг бий болгож байна. Банк тухайлбал ипотекийн зээл гаргахад гар дээр нь бэлэн мөнгө өгчихдөггүй. Үүний оронд

¹⁴ Төв банк мөнгөний нийлүүлэлтэнд харилцах, хадгаламжаас гадна бусад эх үүсвэрийг оруулж тооцдог. Энэхүү өгүүлэлд хялбаршуулах зорилгоор мөнгөний нийлүүлэлт зөвхөн харилцах, хадгаламжаас бүрддэг байдлаар бичлээ. see Burgess and Janssen [11]

¹⁵ Ойролцоогоор гүйлгээнд буй мөнгөний 6 хувь нь Роял Минтийн үйлдвэрлэсэн зоос байдаг. Эдийн засагт эргэлдэж буй мөнгөн дэвсгэрийн зарим хэсэг нь Шотланд болон Хойд Ирландын арилжааны банкуудын гаргасан мөнгөн дэвсгэрт байдаг. Гэсэн ч эдгээр мөнгөн дэвсгэрийг тэдгээр банкны төв банкинд байршуулсан нөөцтэй тэнцүү хэмжээгээр гаргадаг.

¹⁶ Их Британи улсын хувьд 2013 оны 12 дугаар сарын байдлаар

банкн дахь харилцах дансыг нь ипотекийн зээлийн хэмжээгээр нэмэгдүүлдэг. Энэ үед шинэ мөнгө бий болдог. Ийм учраас зарим эдийн засагчид банкны харилцахыг “бэхэн үзэгний мөнгө” буюу банкирууд зээл гаргах үед гарын үсэг зураад л бий болгосон нөөц гэж үздэг.¹⁷ Энэхүү шинэ зээл хэрхэн эдийн засаг дахь салбаруудын тайлан тэнцэлд нөлөөлж буй үйл явцыг Зураг 1-т үзүүлээ. Зураг 1-ийн 3 дахь мөрт үзүүлснээр, шинэ харилцах нь харилцагч (өрх, ААНБ)-ийн хөрөнгийг нэмэгдүүлнэ. Улаан багана нь шинэ зээл тэдгээрийн өр төлбөрийг хэрхэн нэмэгдүүлж байгааг илэрхийлэх буюу шинэ мөнгөний нийлүүлэлт бий боллоо. Үүнтэй ижил, шинэ зээл гарч, шинэ мөнгө бий болсноор арилжааны банкны тэнцлийн хоёр тал аль аль нь өснө. Хэдийгээр Зураг 1-т шинэ мөнгө, шинэ зээл хоёрын хэмжээ яг ижил байхаар хялбаршуулан үзүүлсэн боловч бодит байдал дээр эдгээр нь ялгаатай байх хэд хэдэн хүчин зүйлс бий. Тэдгээрийг дараагийн хэсэгт нарийвчлан танилцуулъя.

Шинэ мөнгөний нийлүүлэлт харилцагчийн тайлан тэнцэл дээр бий болох үед төв банкны нөөц мөнгөнд ямар ч нөлөө үзүүлэхгүй байгааг Зураг 1-ээс харж болно. Өмнө дурдсанчлан, харилцах, хадгаламжийн

¹⁷ Tobin [42] бэхэн үзэгний талаар өгүүлэлдээ дурдаж, банкууд хязгааргүй хэмжээгээр мөнгө бий болгох боломжгүй гэж тайлбарласан.

хэмжээ нэмэгдэх үед банкууд харилцагчийн гүйлгээг хийх, бусад банкуудтай төлбөр тооцоо хийх зорилгоор илүү их хэмжээний нөөцийг төв банкинд байршуулах шаардлагатай болно. Хэвийн үед нөөцийг банкны хүсэлтээр төв банк нийлүүлдэг бөгөөд ингэхдээ банкны тайлан тэнцэл дээрх бусад хөрөнгийг барьцаалан олгодог. Ямар ч нөхцөлд нийт нөөцийн хэмжээ банкны зээл гаргалтыг шууд хязгаарладаггүй.

Мөнгө бий болж буй энэ үйл явц нь банк зөвхөн байгаа мөнгөө л зээлдүүлэх боломжтой гэсэн үзэлтэй зөрчилддөг. Банкны харилцах, хадгаламж нь банк харилцагчиддаа хэдий хэмжээний өр төлбөртэйг илэрхийлэх тэмдэглэл юм. Тиймээс эдгээр нь банкны зээлж болох хөрөнгө бус харин тэдгээрийн өр төлбөр болдог. Үүнтэй холбоотойгоор гардаг өөр нэг ташаа ойлголт бол банкууд нөөцөө зээлж болно гэдэг ойлголт. Харилцагчид төв банкинд дансгүй учраас төв банк дахь нөөцийг зөвхөн банк хооронд л зээлдүүлэх боломжтой.¹⁸

Харилцах, хадгаламжийг бий болгодог, устгадаг бусад арга замууд

Шинээр зээл олгох нь шинэ мөнгийг бий болгодогтой ижил зээлээ буцаан төлөх нь мөнгийг устгадаг.¹⁹ Жишээ нь хэрэглэгч

сарын турш супермаркетад кредит карт ашиглан мөнгөө зарцуулж байсан гэж бодъё. Кредит карт ашиглаж хийсэн худалдан авалт бүр харилцагчийн баланс дахь төлөгдөөгүй зээлийн дүнг нэмэгдүүлж супермаркетин тайлан тэнцэлд харилцах болж нэмэгдэнэ. Хэрэв хэрэглэгч кредит картныхаа төлбөрийг сарын эцэст бүрэн төлвөл, хэрэглэгчийн харилцагч банк түүний харилцах дансны дүнг бууруулж, кредит картных нь тооцоог хийнэ. Ингэснээр шинээр бий болсон харилцахыг буцаагаад устгаж байгаа юм.

Банкууд зээл олгож, харилцагч зээлээ буцаан төлөх нь банкинд харилцах, хадгаламж үүсч, буцаагаад түүнийг устгах хамгийн гол арга нь юм. Гэхдээ үүнээс гадна маш олон аргууд бий. Банкууд ААНБ болон засгийн газраас санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл худалдах тохиолдолд харилцах, хадгаламж бий болгох, эсвэл устгах үйл явц өрнөдөг.

Банкууд ЗГҮЦ-ыг худалдаж авах, худалдах нь эргэлтэд буй нөөцийг нэмэгдүүлэх, устгах гол арга зам болдог билээ. Банкууд хөрвөх чадвартай багцаа бүрдүүлэхдээ ихэвчлэн ЗГҮЦ-ыг худалдаж авдаг бөгөөд хэрвээ хадгаламж эзэмшигчид их

дүнгээр харилцах, хадгаламжаа татах тохиолдолд төв банкинд барьцаалах замаар нөөцөд төвөггүй хөрвүүлэх боломжтой байдаг. Банкууд нь банкнаас бусад санхүүгийн байгууллагаас Засгийн газрын бондыг худалдаж авах тохиолдолд тус харилцагчийн харилцах дансыг нэмэгдүүлдэг. Энэ өгүүллийн төгсгөлд QE-нь үүнтэй адил зарчмаар мөнгө бий болгодог талаар ярилцана.

Үргэлжлэлийг дараагийн дугаарт...

¹⁸ Илүүдэл нөөц, нийт нөөцийг хооронд нь ялгахгүй ашигласнаар зарим буруу ойлголцол үүсдэг.

¹⁹ Тухайлбал, 2008 оноос хойш Их Британид банкны зээл буурсан нь

яагаад мөнгөний өсөлт хямралаас өмнөх үеийн мөнгөний өсөлтөөс нэлээдгүй доогуур байсны чухал шалтгаан болдог Bridges, Rossiter and Thomas [8] and Butt et al [9].



БАНКНЫ САЛБАРЫН РЕФОРМЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Банкны салбарыг эдийн засаг дахь сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэн өөрийн нэрийн өмнөөс зээлдүүлж эсвэл хөрөнгө оруулж гүйлгээнд гаргадаг, ийнхүү санхүүгийн болон бодит салбар хооронд хуваарилалт хийж санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг үндэсний эдийн засгийг хөдөлгөгч чухал механизм гэж ойлгож болно. Ийм учраас банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хуримтлагдаж буй эрсдэлийг бууруулах, удирдах, харилцагчийн эрхийг хамгаалах зорилгоор банк болон түүний үйл ажиллагаа, засаглалд Монголбанкнаас хяналт тавьж, шалгуур үзүүлэлт, шаардлага тогтоодог.

Банкны тухай хууль 2010 онд шинэчлэгдэн батлагдсанаас хойш банк, санхүүгийн салбарын болон техник технологийн хөгжил, нийгэм эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан хуульд нэмэлт, өөрчлөлтүүд оруулан хөгжүүлж ирсэн байдаг. Харин Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сард баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь Монгол Улсын банк санхүүгийн салбарын цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох ихээхэн ач холбогдолтой хууль юм. Энэ хуулийн хүрээнд зарчмын дараах 4 үндсэн асуудлыг хөндөн нарийвчлан зохицуулсан.

Нэгдүгээрт, 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор системд нөлөө бүхий банк нээлттэй хувьцаат компани, бусад банкууд нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн

байгуулагдах зохицуулалтыг Банкны тухай хуульд тусгасан. Энэхүү зохицуулалтын дагуу системд нөлөө бүхий банк гагцхүү нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байх шаардлагатай ба ингэснээр банкны хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж олон нийтэд чөлөөтэй арилжаалах юм.

Системд нөлөө бүхий банкнийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах шаардлагыг хуульчилж, банкууд хувьцаагаа нийтэд санал болгон анх удаагаа гаргах буюу IPO хийснээр банкны үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал сайжирч, хяналтын тогтолцоо илүү боловсронгуй болох, банкны засаглал сайжрах, санхүүгийн хүртээмжтэй байдал нэмэгдэх зэрэг банк, санхүүгийн салбарын экосистемийн тогтвортой хөгжлийг дэмжих боломж бүрдэх ач холбогдолтой.

Үүнтэй холбоотойгоор банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн зохицуулалтад тодорхой өөрчлөлтүүд орсон бөгөөд ТУЗ дэх хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлсэн. Энэ нь банкны засаглалыг бэхжүүлж, оролцогч талуудын эрх ашгийг тэнцвэртэй төлөөлүүлэх ач холбогдолтой.

Хоёрдугаарт, банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах зорилгоор аливаа этгээд дангаараа болон холбогдох этгээдийн хамт банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй хэмжээний хувийг эзэмших зохицуулалтыг тусгасан бөгөөд энэхүү шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүх банк хангасан байх шаардлагатай.

Дээрх хуулийн шаардлагыг хэрэгжүүлснээр банкны өмчлөл, удирдлагын хэт төвлөрсөн байдал арилж, үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод болж, зах зээлийн оролцогчдод мэдээлэл тэгш хүртээмжтэй болох бөгөөд хөрөнгийн зах зээлийн хөгжилд тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлнэ.

Гуравдугаарт, банк татан буугдсан үед төлбөр барагдуулах дарааллыг ойлгомжтой болгох, хуримтлалтай иргэн, өрхийн хууль ёсны эрхийг хамгаалахад чиглэсэн байдлаар оновчтой байлгах зохицуулалт юм. Тухайлбал хуримтлалтай иргэн, өрхийн хууль ёсны эрхийг хамгаалах үзэл баримтлалын хүрээнд иргэд тэргүүн ээлжид

хадгаламж болон харилцах данс дахь өөрийн мөнгөн хөрөнгийг хуулийн этгээдээс өмнө буюу тэдгээрээс тэргүүн ээлжид авах зохицуулалтыг тусгаж өгсөн. Дараа нь хуулийн этгээд, түүний дараа Засгийн газар, төрийн байгууллагууд байхаар төлбөрийн дарааллыг нарийвчлан зохицуулсан.

Үүний хүрээнд албадлагын арга хэмжээтэй холбоотой доорх журмуудыг батлуулсан эсвэл боловсруулах шатандаа явж байна:

- “Банканд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам”-ын төсөл;
- “Банканд нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх, бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журам”-ын төсөл;
- “Банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам”-ын төсөл;
- “Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ын төсөл;
- “Банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний журам”-ын төсөл;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-155 дугаар тушаалаар “Банкны тогтворжуулалтын сангийн журам”-ыг батлуулсан;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-226 дугаар тушаалаар “Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам”-ыг батлуулсан.

Дөрөвдүгээрт, банкны системд нөлөө бүхий банкны тодорхойлолтыг нарийвчлан боловсронгуй болгож хуульчилсан. Банкны тухай хуулийн энэ өөрчлөлтөөр зөвхөн зах зээлд эзлэх хувиар бус банкны хөрөнгө, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал, мөн харилцагчдын тоо зэрэг бусад хүчин зүйлсийг баримтлан Монголбанк тогтооно. Энэ нь системд нөлөө бүхий банкнийг тэдгээрийн хөрөнгийн хэмжээгээр бус нийгэмд эзлэх байр суурь, ач холбогдолтой уялдуулж буй явдал бөгөөд тодорхойлолтыг ийнхүү илүү оновчтой болгосон нь банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх ач холбогдолтой.



ОЛОН УЛСЫН КОРРЕСПОНДЕНТ БАНКНЫ ХАРИЛЦААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Корреспондент банкны харилцаа гэдэг нь нэг банк өөр банкуудын мэдлийн татан төвлөрүүлсэн хөрөнгийг байршуулан, тэдгээрт төлбөрийн болон бусад үйлчилгээ үзүүлэх тохиролцоо юм. Энэхүү тохиролцоог зарим үед дотоодын нөхцөлд агентын харилцаа гэдэг. Корреспондент банкуудын харилцаа нь гадаад валютын арилжааны төлбөр тооцоо хийхэд ностро болон востро гэсэн дансуудыг ашигладаг.

Корреспондент банкны харилцаагаар дамжуулан банкууд өөр улс орнуудын санхүүгийн үйлчилгээнд нэвтэрч, харилцагчдадаа хил дамнасан төлбөрийн үйлчилгээг үзүүлж, олон улсын худалдаа, санхүүгийн хүртээмжийг дэмжих боломж олгодог чухал ач холбогдолтой юм. Харин 2008 оны санхүүгийн хямралаас хойш дэлхий дахинаа корреспондент банкны харилцаа буурч, эрсдэлээс зайлсхийх зорилгоор хязгаарласан тохиолдол ихээр ажиглагдах болсон. Ялангуяа эдгээр үйлчилгээг үзүүлж буй зарим банкууд тогтоосон харилцааныхаа тоог цөөлж, шинээр цөөн хэдэн харилцаа тогтоох болсон байна [1].

Үүний зэрэгцээ Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын

стандартыг 2012 онд шинэчилсэн. Улмаар улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх аргачлалд өөрчлөлт оруулж, хууль тогтоомжийн үр дүнтэй хэрэгжилтэд нэлээд ач холбогдол өгөх болсон. Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хорооноос 2019 онд мэдэгдсэнээр 2011-2018 оны хооронд корреспондент банкны харилцааны тоо 20 хувиар багассан байна. Тухайлбал, комплаенсийн зардал нэмэгдсэн, бизнесийн нэр хүнд болон ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй зэрэг асуудлаас үүдэлтэй гэжээ [2].

Мөн Дэлхийн банк болон Олон улсын бусад байгууллагуудаас гадаад төлбөр тооцоонд хүндрэл үүссэн тохиолдолд идэвхтэй байгаа корреспондент банкны харилцаагаа сайжруулах, бэхжүүлэх, харилцаагаа авч үлдэх чиглэлээр тогтмол холбогдох арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж зөвлөдөг. Гэсэн хэдий ч олон улсад корреспондент банкны харилцааг хумьж, эрсдэлээс зайлсхийх арга хэмжээг дэлхийн томоохон банкууд авсаар байна. Үүнтэй холбоотойгоор Дэлхийн банкнаас корреспондент банкны харилцааны нөхцөл байдал, чиг хандлага, цаашид авбал зохих арга хэмжээний талаар хийсэн

судалгааг багцлан дараах байдлаар тайлбарлав.

ЭРСДЭЛЭЭС ЗАЙЛСХИЙХ АРГА ХЭМЖЭЭ

Өнөөгийн олон улсын корреспондент банкны харилцаанд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл бол эрсдэлээс зайлсхийх арга хэмжээ юм. Эрсдэлээс зайлсхийх гэдэг нь санхүүгийн байгууллагууд эрсдэлийг удирдах бус харин түүнээс зайлсхийхийн тулд өндөр эрсдэлтэй гэж тооцогдсон харилцагчтай бизнесийн харилцаагаа таслах, хязгаарлах арга хэмжээг хэлнэ [3]. Ашиг багатай, бизнесийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтайгаас гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хяналт шалгалт нэмэгдэж байгаагаас үүдэн эрсдэлээс зайлсхийх хүрээнд АНУ, Их Британи, Австрали дахь корреспондент банкны харилцаа хумигдахад хүрсэн. Олон улсын корреспондент банкны харилцааны хувьд зохицуулалтын арга хэмжээтэй уялдуулан корреспондент банкууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсаар байна.

Дэлхийн банкнаас корреспондент банкны харилцааны талаарх судалгааг нийт 91 банкны салбарыг зохицуулагч байгууллага, 20 том хэмжээний банк, 170 бүс нутгийн болон дотоодын жижиг банкуудыг хамруулан хийж, улмаар корреспондент харилцаа яагаад буурсан, мөн харилцааг зогсоох болсон шалтгааныг судалжээ [4]. Уг судалгааны үр дүнг инфографикт ерөнхийлөн харууллаа.

ОЛОН УЛСЫН КОРРЕСПОНДЕНТ БАНКНЫ ХАРИЛЦААНД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

- Корреспондент банкны харилцааг цуцалсан гол шалтгаанууд

Дэлхийн банкны судалгаанд олон улсын корреспондент банкны харилцааг цуцлахад нөлөөлсөн хэд хэдэн голлох шалтгаануудыг дурдсан байсан. Үүнээс судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 64 хувь нь корреспондент банкны харилцаатай байх нь ашиггүй учир корреспондент банкны харилцаагаа цуцалж байна гэжээ. Удаагаар нь ерөнхий эрсдэл өндөр, хууль эрх зүй, зохицуулалт болон хяналт шалгалтын өөрчлөлтүүд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй зэрэг

шалтгаанууд корреспондент банкны харилцааг бууруулахад нөлөөлсөн байна. Уг шалтгаануудаас үүдэн корреспондент банкны харилцааг хамгийн өндөр хувиар зогсоосон улс орнуудад 84 хувийн үзүүлэлтээр АНУ, удаагаар нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Европын холбооны улс орнууд тэр дундаа Швейцарь болон Канад улс багтсан байна. Эдгээр улсууд нь дэлхийн санхүүгийн системд чухал нөлөө үзүүлдэг төдийгүй корреспондент банкны харилцаагаа хумьснаар төлбөр тооцооны хугацаа, гүйлгээний шимтгэл ихсэх болон санхүүгийн хүртээмжийг багасгах гэх зэрэг олон сөрөг үр дагавруудыг дагуулж байгаа юм.

- Корреспондент банкны харилцаанд гарч буй чиг хандлага

Ностро дансны бууралт: Ностро данс гэдэг ойлголт нь энгийнээр гадаадын банканд нээсэн дотоодын банкны данс юм. Корреспондент банкны харилцаанд ностро дансыг ашиглаж гадаад валютын арилжааны төлбөр тооцоог хийдэг. Олон улсын корреспондент банкны харилцаанд ажиглагдаж байгаа бас нэг томоохон чиг хандлага бол Ностро дансны бууралт юм. Дэлхийн банкны асуулгад бүрэн хариулсан нийт 91 банкны салбарыг зохицуулагч байгууллагын 54 хувь нь Ностро дансанд бууралт гарсан гэж хариулсан бол зөвхөн 2 хувь нь мэдэгдэхүйц өсөлт гарсан үзүүлэлттэй байсан талаар мэдээлсэн. Үүнээс Латин Америк, Карибын тэнгисийн орнууд хамгийн их хямралд өртсөн байна. Харин манай улсын хувьд Зүүн Азийн бүс нутагт харьяалагддаг бөгөөд дийлэнхдээ өөрчлөлт багатай байгаа гэж хариулсан хэдий ч уг бүс нутагт харьяалагддаг улс орнуудын 24 хувь нь ностро данс бага зэргийн бууралттай, 18 хувь нь мэдэгдэхүйц буурсан үзүүлэлттэй байгаа гэжээ.

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртгийн өсөлт: Дэлхийн банкнаас улирал тутам эрхлэн гаргадаг мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртөг, зардлыг дүгнэх зорилготой тайлан судалгаанд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар дэлхий дахинд 200 ам.доллар шилжүүлэх дундаж өртөг нь нийт дүнгийн 6.30 хувь буюу 12.6 ам.доллар байна гэх үр дүн гарчээ [5]. Дэлхийн банкнаас уг төрлийн

судалгааг 2008 оноос хойш эрхлэн гаргаж, томоохон мөнгөн гуйвуулгын сувгуудаар дамжуулан мөнгийг шилжүүлэх зардал өртөгт шинжилгээ хийдэг байна. Түүнчлэн энэхүү судалгаанд зөвхөн банк бус, бүх төрлийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулан авч үздэг. Хамгийн сүүлд хийгдсэн судалгааны үр дүнд Зүүн Азийн бүс нутаг мөнгө хүлээж авах үед хамгийн зардал багатай (нийт мөнгөн дүнгийн 4.49%), Африкийн Сахарын цөлөөс урагш бүс нутаг мөнгө хүлээн авах үед хамгийн өртөг өндөр (8.27%) байжээ. Улмаар банк нь мөнгөн гуйвуулгын зардлын хувьд хамгийн өндөр өртөгтэй (10.40%) үйлчилгээ үзүүлэгч болсон байна.

Иймд дүгнэж харахад өнөөгийн корреспондент банкны харилцааны чиг хандлага нь зардал өсөх, зохицуулалтын шаардлагууд улам бүр нэмэгдэх болон хүлээгдэж буй эрсдэл өндөр байгаа нь корреспондент үйл ажиллагааны ашгийн хэмжээг бууруулж, улмаар корреспондент банкны харилцааг сайжруулах боломжийг хязгаарлан, тааламжгүй нөхцөлийг бүрдүүлж байна. Ялангуяа эдийн засгийн цар хүрээ энэ төрлийн бизнест ихээхэн нөлөөлдөг бөгөөд зарим банкууд ашиг орлогоороо комплаенсийн зардлаа нөхөхөд хүндрэлтэй болоод байна. Улмаар энэ төрлийн бизнес нь “бага эрсдэл - бага ашиг” бизнесийн төрлөөс “өндөр эрсдэл - бага ашиг” төрөлд шилжих хандлагатай байна.

Үргэлжлэл бий.

Ашигласан материал:

[1] Олон улсын төлбөр тооцооны банк. “Correspondent banking.” BIS.org. Jul.2016, <https://www.bis.org/cpmi/publ/d147.pdf>

[2] Европын төв банк. “Eleventh survey on correspondent banking in euro.” ECP Europa Publications. Nov.2020, <https://www.ecb.europa.eu/pub/pdf/other/ecb.eleventhsurveycorrespondentbankingeuro202011-c280262151.en.pdf>

[3] US Department of State. “Threat Finance Countermeasures.” State.gov Archived content. Accessed February 18, 2022. <https://2009-2017.state.gov/e/eb/tfs/tfc/index.htm>

[4] Дэлхийн банк. “Withdrawal from correspondent banking Where, Why, and What to Do About it.” Finance and Markets Global Practice, The World Bank Group. Nov.2015, 101098-revised-PUBLIC-CBR-Report-November-2015 (1).pdf

[5] Дэлхийн банк. “An analysis of trends in cost of remittance services. Remittance prices worldwide quarterly.” The World Bank Reports, Issue 39. Sep.2021, https://remittanceprices.worldbank.org/sites/default/files/rpw_main_report_and_annex_q321.pdf

“БАР ЖИЛ”

Дурсгалын мөнгөн зоос



Монголбанкны Эрдэнэсийн сангаас XVII жарны “Буян үйлдэгч” хэмээх усан бар жилд зориулан “Бар жил” 1 унцын 999 сорьцтой мөнгөн зоосыг худалдаанд гаргалаа.

12 жилийн дурсгалын зоосны цувралыг 2020 онд “Хулгана жил” дурсгалын мөнгөн зоосоор эхлүүлж, 2021 онд “Үхэр жил” дурсгалын мөнгөн зоосыг худалдаанд гаргаж байв.

Энэхүү цуврал нь Монголын уламжлалт зурхайд дүрсэлснээр хүмүүн биетэй, 12 жилийн тэргүүнтэй, махбодын өнгө зүстэй, мутартаа 12 жилийн бэлэг тэмдгийг барьсан бөгөөд уламжлалт зургийн аргаар зурж, бүтээснээрээ онцлог юм. Энэхүү цуврал дурсгалын зоосыг хамгийн сүүлийн үеийн Smartminting технологиор урласан байна

Банк олон нийтэд хувьцаагаа гаргаж, нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлын талаарх тодруулгыг тус буланд онцоллоо



Монголын банкны холбооны
Гүйцэтгэх захирал

Л.АМАР

**ӨМЧЛӨЛИЙН ХЭЛБЭРИЙГ
ОЛОН УЛСЫН ЖИШИГТ
ХҮРГЭСНЭЭР ДАРААЧИЙН
ШАТАНД ГАРАХ ШАЛГАРАЛ
ӨРНӨЖ БАЙНА**

Банкууд IPO (Initial public offering) гаргаснаар банкны үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, хяналтын тогтолцоо илүү боловсронгуй болох, банкны засаглал сайжрах, санхүүгийн хүртээмжтэй байдал нэмэгдэх зэрэг банк, санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ. Ялангуяа, хувьцаа эзэмшигчдийн харилцан хяналт тогтсоноор хэн нэгний эрх ашиг давамгайлах байдал арилж, холбоотой этгээдэд зээл олгох гэх мэт асуудлууд хязгаарлагдана.

Банкны тухай хуулийн дагуу арилжааны банкууд ХХК-аас ХК

хэлбэрт шилжих үүрэг хүлээсэн. Системийн нөлөө бүхий таван банкны хувьд нээлттэй, бусад нь хаалттай эсвэл нээлттэй хэлбэрт шилжих ёстой. Банкны салбар нь дүрэм, журмаа мөрддөг салбар. Тиймээс хуульд заасан хугацаанд буюу 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хэтрэхгүй IPO-оо хийхээр бэлтгэл ажлаа хангаад, шаргуу ажиллаж байна.

IPO хийхэд цаг, хугацааны хувьд шахуу байгаа. ОУВС-ийн зүгээс ч, цаг хугацааны хувьд шахамдуу байна, дээрээс нь AQR (активын чанарын үнэлгээ) хийлгэ гэдэг шаардлага тавьсан. Гэхдээ манай банкны салбарын хувьд давуу тал бий. Банкууд олон улсад хүлээн зөвшөөрөгддөг аудитын компаниар өнгөрсөн хугацаанд аудит хийлгэж ирсэн учраас бэлтгэл ажил гайгүй хангагдаж байна гэж ойлгож болно. Харин бэлтгэл ажлын хажуугаар активын чанарын үнэлгээ хийлгэж, зээлийн чанараа шалгуулбал, мэдээж хэрэг цаг хугацааны хувьд өөрчлөлт орно. Энэ тохиолдолд банкууд бараг нийтээрээ зэрэгцээд 6 дугаар сардаа IPO гаргах болов уу.

Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцоо үүсэж, хөгжөөд

31 жил болж байна. Өнгөрсөн хугацаанд банкны салбар нь санхүүгийн зах зээлийн 90 орчим хувийг бүрдүүлж, давамгайлж ирсэн бөгөөд ширүүн өрсөлдөөн, шалгарал үргэлжилсээр өнөөдөр энэ салбарт 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр Монгол Улсын банкны салбар нь төлбөр тооцоо, цахим хөгжлөөрөө хөгжиж буй болон зарим хөгжингүй улс орнуудтай харьцуулахад хамаагүй түрүүлж, хөгжжээ. Банкууд технологи хөгжүүлэлтэд л гэхэд жилд 100 сая ам.доллар зарцуулж, банкны салбарын үйлчилгээ илүү хүртээмжтэй, шуурхай, найдвартай болсоор буй. Тэгвэл 2021 оны 1 дүгээр 29-ний өдрөөс хэрэгжиж буй Банкны тухай шинэ хуулийн хүрээнд банкуудын өмчлөлийн хэлбэрийг олон улсын жишгийн дагуу олон нийтийн өмчийн хэлбэрт шилжүүлж, хөгжлийнхөө дараачийн шатанд гарах ээлжит нэгэн шалгарал өрнөж байна. Нөгөө талдаа уг шинэчлэл нь манай санхүүгийн тогтолцоонд үгүйлэгдэж ирсэн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын хөшүүрэг болж, санхүүгийн салбарт төрөлжилтийг авчирч, тогтвортой санхүүгийн системийг бий болгох юм.



Хаан банкны гүйцэтгэх захирал

Р.МӨНХТУЯА

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭД
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИХ,
ТҮҮНЭЭС ӨГӨӨЖ ХҮРТЭХ
БОЛОМЖИЙГ НЭЭЖ ӨГЧ
БАЙГАА ТҮҮХЭН АЧ
ХОЛБОГДОЛ БҮХИЙ ҮЙЛ
ЯВДАЛ ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА**

Дэлхийн банкны гишүүн байгууллага болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) ХААН Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон 2004 оны үеэс эхлэн манай банк олон улсын стандартад нийцсэн компанийн зохистой сайн засаглалын тогтолцоог бүрдүүлэхээр зохистой засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.

Өнгөрсөн хугацаанд бид зохистой сайн засаглалыг амжилттай хэрэгжүүлснээр Монгол Улсын үндэсний хэмжээний хүчирхэг, тэргүүлэгч арилжааны банк болж чадсан. Өөрөөр хэлбэл, сайн зохистой засаглалын олон улсын зарчмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласнаар олон улсын санхүүгийн зах зээлээс урт хугацаат санхүүжилт босгох боломжийг нээж өгсөн гэж хэлж болно. Үүний үр дүнд 2009 оноос

хойш ХААН Банк 1,3 тэрбум ам.долларын санхүүжилтийг олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн банкуудаас авч бизнес эрхлэгч харилцагч нартаа санхүүжилт олгож ирлээ.

Компани зохистой сайн засаглалтай байх нь Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын багийн хараат бусаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр дотоод хяналтын тогтолцоо сайжирч, компанийн үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу ХААН Банк энэ онд хувьцаат компани болж олон нийт, мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагч нар банкны хувьцаа эзэмшигч болсноор олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэж, бидний одоогийн хэрэгжүүлж буй зохистой сайн засаглалын баримт бичгүүд илүү төгөлдөршинө гэж үзэж байна.

Монгол Улсын санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 80 хувийг банкны салбар бүрдүүлдэг. Тэр дундаа банкны салбарынхаа нийт актив хөрөнгийн 94 хувийг бүрдүүлж байгаа системийн нөлөө бүхий таван банк нэг жил хагасын хугацаанд хувьцаагаа анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгож, хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааг зохион байгуулна гэдэг харьцангуй богино хугацаа юм. Топ таван банкны IPO хийгдсэнээр

ойролцоогоор 600-800 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хөрөнгийн зах зээл дээрээс татах болов уу гэж харж байна. Ийм хэмжээний хөрөнгө амжилттай босгох нь Монголын хөрөнгийн зах зээлийн багтаамж, хөрвөх чадвар, хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх олон нийтийн санхүүгийн боловсрол, мэдлэг зэрэг маш олон хүчин зүйлсээс хамаарна. Харин ХААН Банкны тухайд хуулийн хугацаандаа багтаан олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний дагуу ажиллаад явж байна.

Тодруулбал, Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3-р сарын 26-ны өдрийн А-90/85 тоот хамтарсан тушаалаар батлагдсан журмын дагуу “ХААН Банк” ХХК нь “Банкны үнэт цаас гаргах дэлгэрэнгүй төлөвлөгөө”-г боловсруулан Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанканд хүргүүлсэн бөгөөд ХААН Банкны олон нийтэд үнэт цаас гаргах төлөвлөгөө хэрэгжих боломжтой гэж үзэн зөвшөөрөл олгосон. Энэхүү батлагдсан төлөвлөгөөний дагуу банк бэлтгэл ажлаа хангаж байгаагийн зэрэгцээ улирал тутам төлөвлөгөөний дагуу хийж буй ажлын тайлангаа Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн ажиллаж байна.

Үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй

хөндлөнгийн хараат бус мэргэжлийн байгууллагууд болох үндсэн андеррайтер, хуулийн нөхөрлөл, аудит, үнэлгээний компаниудтай бид 2021 оны 5-р сард гэрээ байгуулан хуульд заасан үнэт цаасны танилцуулгад тусгах тайлан, дүгнэлтүүдийг гаргуулахаар ажиллаж байна.

Арилжааны банкууд нээлттэй хувьцаат компани болж хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурснаар Монгол Улсын нийт иргэд банкны хувьцаа эзэмших, түүнээс өгөөж хүртэх боломжийг нээж өгч байгаа түүхэн ач холбогдол бүхий үйл явдал гэж үзэж байна. Үүнээс гадна арилжааны банкууд нээлттэй хувьцаат компани болсноор зохистой сайн засаглалын тогтолцоо сайжирч, үүнийг дагаад гадны мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагчийг татах боломжийг бий болгох юм. Цаашлаад гадаадын хөрөнгийн зах зээл дээр гарах, хөрөнгө оруулалт татах, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулж зах зээлээ тэлэх боломж нээгдэх болов уу гэж харж байна.



ХасБанкны Гүйцэтгэх захирал

Г.ЦЭВЭГЖАВ

**БАНКНЫ ТУХАЙ ШИНЭ
ХУУЛЬ НЬ БАНК САНХҮҮГИЙН
ТОГТОЛЦООГ ШИНЭЧЛЭХ
ЧУХАЛ СУУРЬ БОЛСОН**

2021 онд банкны салбарын шинэчлэлд чухал нөлөөтэй 2 томоохон өөрчлөлт хуульд орсон нь арилжааны банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, улмаар засаглалыг сайжруулж, ил тод нээлттэй болгоход чиглэгдсэн алхмууд байлаа. Эдгээр нь банкны салбарын маш зөв шинэчлэлээс гадна нэг хувьцаа эзэмшигч 20%-аас ихгүй хувь эзэмших болон системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох шаардлагууд нь олон улсын жишиг, стандартад ойртсон гарцаагүй хийгдэх ёстой өөрчлөлтүүд гэж үзэж байгаа.

Хувь эзэмшлийн төвлөрөл буурна гэдэг нь энгийнээр хэлэхэд, нэг хүн давамгай шийдвэр гаргахгүй, компанийн засаглал зөв, ил тод, үйл ажиллагаа явуулахад боловсронгуй хялбар байхад чиглэсэн хэрэг.

ХасБанк одоогоос 10 жилийн өмнө олон нийтийн нээлттэй компани болох алсын хараа боловсруулан ажиллаж ирсэн.

Хэдэн арав, бүр хэдэн зуун мянган хүн манай хувьцааг худалдаж авах боломжтой болох үүднээс манай банк бодлого, стратегийнхаа хүрээнд нэг хувьцаа эзэмшигчид хэт төвлөрөл үүсгэх нь зохимжгүй гэж үзсээр ирсэн. Үүнийхээ үндсэн дээр тогтоосон дээд хэмжээ нь 20 хувь байсан. Өнөөдрийн байдлаар ХасБанк олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын болон дотоодын нэр хүндтэй 12 хувьцаа эзэмшигчтэй. Тэдний долоо нь тус бүр таваас дээш хувь эзэмшдэг стратегийн нөлөө бүхий хөрөнгө оруулагчид. Стратегийн хөрөнгө оруулагчид зөвхөн мөнгө хөрөнгөөр үл хэмжигдэх дэлхийн санхүүгийн мэдлэг туршлага, олон улсын ололт амжилт, жишиг стандартаас оюуны хөрөнгө оруулдаг давуу талтайгаас гадна хамгийн том давуу тал нь компанийн засаглалыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчид өөрийнхөө төлөөлөн удирдах зөвлөлөө болон хараат бус гишүүдээ сонгон томилдог. Томилогдсон ТУЗ-ийн гишүүд нь гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын ажилд оролцохгүйгээр хяналт тавин ажилладаг ба энэ нь мэргэжлийн удирдлагын баг ажлаа мэргэжлийн түвшинд хараат бусаар хийж гүйцэтгэх боломжийг олгодог.

Банкны тухай шинэ хууль нь банк санхүүгийн тогтолцоог шинэчлэх чухал суурь болсон. Ганц санаа зовоож байгаа зүйл нь хуулийн хэрэгжих хугацааны

тухайд хэт богино байгаа. Өөрөөр хэлбэл системийн хэмжээнд аваад үзэхэд цаг хугацааны хувьд давчуу гэж хэлж болно. Олон улсын жишгээр компаниуд нээлттэй ХК болоход дор хаяж 3 жил бэлтгэл ажлаа хангадаг нь элбэг. Учир нь хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татна гэдэг нь компанийн хувьд маш өндөр үүрэг хариуцлага хүлээж байгаа явдал. Том реформыг дэндүү богино хугацаанд хийснээр олон эрсдэл гарч болзошгүй. Тухайлбал, банк нээлттэй ХК болоход хөрөнгө татах зах зээлийн багтаамж хангалттай бий бил үү? Сүүлийн үед олон компани Монголын хөрөнгийн зах зээлд IPO болон нээлттэй бонд гаргаж байна. Энэ үйл явц цаашид үргэлжилсээр байна. Мөн Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал гадаад дотоод хүчин зүйлсээс шалтгаалан амаргүй байгаагаас гадна Ковид-19 цар тахлын нөлөө одоо хүртэл банкны салбарт сорилт болсоор байна.

Урьдчилсан байдлаар Системийн банкнууд IPO хийхэд нийт 700-800 тэрбумын хөрөнгө татах шаардлагатай гэсэн тооцоо гарсан. Энэ хэмжээний зах зээлийн багтаамж, ийм мөнгө оруулах хүсэлтэй гадаад дотоодын иргэд, аж ахуйн нэгж байна уу гэдэг асуулт дагуулсан том эрсдэл ургаж таарна.

Хэдийгээр ХК болох богино хугацаа байгаа боловч ХасБанкны хувьд 10-аад жилийн өмнөөс нээлттэй компани болох алсын хараа боловсруулан ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн бүтэц,

засаглалын зарчмуудаа үүнд чиглүүлж ирсэн тул харьцангуй бэлтгэлтэй гэж хэлж болно.

Манай банкны хувьд ойрын жилүүдэд ийм реформ бий болно гэсэн хүлээлт байсан учраас энэ чиглэлд бид бизнесээ төлөвлөж, бэлтгэлээ хангаж байсан. Өнгөрсөн онд нээлттэй хувьцаа гаргах санхүүгийн төлөвлөгөөгөө банкны хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д танилцуулж батлуулсны дараа Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороонд хуулийн дагуу 2021 оны долдугаар сарын 1-нээс өмнө гаргаж өгөх үүргээ биелүүлсэн. Одоо бид хөндлөнгийн аудит, үнэлгээний компани, андеррайтер, хуулийн фирм гээд олон байгууллагатай хамтран ажиллаж, үнэт цаасны танилцуулгаа бэлтгэж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх ажил дуусаад бид Монголбанк, СЗХ-нд ХК болох хүсэлтээ албан ёсоор өгнө. Үүний дараа олон нийтэд хувьцаагаа санал болгох үйл явцыг эхлүүлэх эрх бидэнд үүсэх юм.

Эцэст нь, банкны салбарын шинэчлэл бол гарцаагүй хийх ёстой зүйл. Хуульд өөрчлөлт орж, батлагдах үед бид дэмжин хүлээн авч, энэхүү шинэчилсэн зохицуулалт нь ХасБанкны өсөлт хөгжилд хувь нэмрээ оруулах, цаашлаад хувьцааг нь ил тодоор, нээлттэйгээр шууд эзэмших боломжийг Монгол Улсын иргэн бүрд ижил тэгш олгоно гэж үзэж байгаагаа хамгийн түрүүнд илэрхийлж байснаас гадна манай хувьд одоо хэрэгжүүлэх л ажил үлдээд байна.



Богд Банкны гүйцэтгэх захирал

Г.САРУУЛ



**БАНКЫГ НЭЭЛТТЭЙ
БОЛГОЖ БАЙГАА НЬ
ГАДНААС ХӨРӨНГӨ ТАТАХ,
ВАЛЮТЫН ОРОХ УРСГАЛЫГ
НЭМЭГДҮҮЛНЭ**

Богд банк нь банкны салбарт анхны нээлттэй хувьцаат компани болсон нь нийтэд ил тод болж буй хэрэг бөгөөд тэр хэмжээгээр хадгаламж эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлэх давуу талтай. Олон жил хувьцаа эзэмшлийн мэдээлэл хаалттай явсан тэр тогтолцоог халж өөрчлөгдөж байгаа нь компанийн засаглал, үйл ажиллагаа болон удирдлагын түвшинд илүү хариуцлагатай болж өсөх үр нөлөөтэй юм. Банк хөрөнгийн зах зээлд зохицуулалттай болж байгаа нь санхүүгийн секторт маш чухал үйл явдал гэж харж байгаа.

2021 оны 1 дүгээр сарын 29-ний УИХ-ын шийдвэрээр Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж бүх арилжааны банкууд хувьцаат компани хэлбэртэй байхаар хуульчилсан. Богд банкны тухайд тухайн шийдвэр гарахаас ч өмнө олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохоор

төлөвлөн зорьж ажиллаж байсан бөгөөд банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Богд банкны зорилттой шууд нийцэж байсан тул хуульд нэмэлт өөрчлөлт орсны дараагийн өдөр буюу 2021 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэлтэй арилжааны банк болохоо нийтэд зарлаж ажилдаа орж, 2021 оны 12 дугаар сарын 01-нд анхдагч IPO арилжаагаа олон нийтэд нээлттэй зарлаж, төлөвлөгөөгөө 104.5 хувиар биелүүлэн, 31.75 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж чадсан нь хөрөнгө оруулагч Бидний зорилго бол уламжлалт банкны үйлчилгээнээс гадна дижитал шийдэл, технологийн боломжийг зоригтой нэвтрүүлж, энэ чиглэлд түлхүү хөрөнгө оруулахын төлөө ажиллаж байна.

Банк бол маш олон зууны түүхтэй байгууллага. Хөгжил дэвшлийнхээ шатанд банк нь маш олон үеийг туулж, түүнийг даван шинэчлэгдэн сайжирч, боловсронгуй болон өдийг хүрсэн. Банкууд хөрөнгийн бирж дээр IPO хийх нь зөвхөн дотоодын гэлтгүй гадны хөрөнгө оруулагчдад ч банкыг нээлттэй болгож байгаа нь гаднаас хөрөнгө татах, валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээл дээр МУ-ын нэр хүндийг өсгөх, дотоодын бизнесийн стандартыг сайжруулах зэрэг олон ач холбогдолтой.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 29/IV ӨДРИЙН БАЙДЛААР)



© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2021

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Г. Амартүвшин¹, Б. Мөнх-Эрдэнэ²

Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн улс орнууд ойрын 80 орчим жилд тохиолдоогүй гэнэтийн, гүн хямралтай нүүр тулав. Аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээ, тээвэр зэрэг эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа богино хугацаанд хумигдаж, цар тахлын цохилтод хүчтэй өртлөө. Вирусын шинэ хувилбарууд үүсэж, улс орнууд хямралын давхар давалгаатай тулгарч эхэлсэн бөгөөд эрүүл мэндийн системийн хувьд үүссэн хүндрэл бэрхшээл, дотоод хүчин зүйлсээс үүдэлтэй эдийн засаг дахь доголдлууд, гадаад эрэлтийн огцом агшилт, хөрөнгийн гадагшлах урсгал, тээвэр, логистикийн доголдлууд, хувьцааны үнийн уналтууд зэрэг нь 2020 онд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлыг хүндрүүлэв. Иймээс улс орнууд хямралыг даван туулж, эдийн засгийг сэргээх зорилгоор төсвийн шинжтэй багц хөтөлбөрүүдийг зарлаж, төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын цогц арга хэмжээг өргөн хүрээнд авч хэрэгжүүлсэн байна. Харин 2021 оноос эхнээс улс орнуудад вакцинжуулалт эрчимжиж эдийн засгаа шат дараатай нээсэн, зарим том гүрнүүдэд төсвийн санхүүжилтүүд нэмэгдсэн нь зах зээлд эерэг дохиог өгч, эдийн засгийн идэвхжил болон түүхий эд, металлуудын үнэ өсөхөд нөлөөлсөн юм. Үүний зэрэгцээ нийлүүлэлтийн сүлжээний доголдол, тээвэр, логистикийн асуудалтай холбоотойгоор нийлүүлэлтийн гаралтай инфляц, хөдөлмөрийн нийлүүлэлтээс үүдэлтэй цалингийн өсөлт нь улс орнуудад

¹ Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн ахлах эдийн засагч. Цахим шуудан: amartuvshin.g@mongolbank.mn

² Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн эдийн засагч.

Цахим шуудан: bmunkherdene@mongolbank.mn

инфляцыг өдөөж эхлэв. Улмаар эдийн засгийн сэргэлт болон инфляцын дарамттай холбоотойгоор зарим улсын Төв банкууд 2021 оноос бодлогын хүүгээ нэмэгдүүлж эхэлсэн байна. Монгол Улсын хувьд хөдөлмөрийн зах зээл төдийлөн сэргээгүй, хувийн хэрэглээний өсөлт нам түвшинд, хилийн хязгаарлалттай холбоотойгоор экспорт хүлээлтээс бага байснаар эдийн засгийн идэвхжил төдийлөн сэргээгүй. Харин нөгөө талаас нийлүүлэлтийн гаралтай инфляц 2021 оны 2 дугаар хагасын турш өндөр байсан нь инфляц эрчимжиж зорилтот түвшин (6 ± 2)-ээс давахад нөлөөлөв. Энэхүү судалгааны нийтлэлээр Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлсэн нөлөө, үүний хариуд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний талаар багцлан танилцуулахыг зорилоо.

Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлсэн нөлөө, үүний хариуд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

Ковид-19 цар тахал Монгол Улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт төлбөрийн тэнцлийн, орлогын, зээлийн сувгуудаар дамжин нөлөөлөв. Тодруулбал, цар тахлаас шалтгаалан 2020 онд гадаад эрэлт муудах, эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах, гадаад худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтууд удаашрах хандлагууд бий болж байв. Энэ нь орлогын сувгаар дамжин төсвийн орлого буурах, аж ахуйн нэгжүүдийн орлого тасалдах, цаашлаад өрхүүдийн цалин, хөлсний орлого буурах зэргээр илэрч, эдийн засаг 2020 онд 4.6 хувиар огцом агшлаа. Үүнийг дагаад зах зээлийн тодорхой бус байдал нэмэгдэж, банк, санхүүгийн байгууллагуудын үйл хөдлөл зээлийн нөхцлөө чангаруулах, зээл олголтоо хумих чиглэлд шилжсэн бөгөөд зээлийн сувгаар дамжин бодит эдийн засаг улам хүндрэх нөхцөл байдал үүссэн буюу банкуудын зээлийн үлдэгдэл 2020 онд 5 хувиар буурсан байна. Энэ үед зохицуулагч байгууллагуудын зүгээс хөнгөлөлт, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, эдийн засгийн хүндрэлийг зөөлрүүлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн юм.

Төлбөрийн тэнцлийн суваг: Цар тахлаас шалтгаалан 2020 оны эхний хагаст суурь металлуудын үнэ 17 орчим хувиар, түүхий нефтийн үнэ 40 орчим хувиар унаж, худалдааны нөхцөл муудав. Үүнтэй зэрэгцэн 2020 оны 2, 3 дугаар сард манай улсын талаас БНХАУ-тай хиллэдэг боомтуудыг хааж, 40 гаруй хоногийн хугацаанд нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн экспортыг түр зогсоосон нь гадаад худалдаанд сөргөөр нөлөөлж, 2020 оны эхний 4 сард урсгал данс 1 тэрбум орчим ам.долларын алдагдалтай гарсан. 2021 оны эхнээс дэлхийн улс орнуудад вакцинжуулалт амжилттай хийгдэж, төсвийн багц хөтөлбөрүүд сунгагдаж, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлснээр манай улсын гадаад эрэлтийн төлөв сайжирч, экспортын орлого нэмэгдэж эхлэв. Гэвч 2021 оны 3, 4 дүгээр сард БНХАУ-ын талаас хилийн хязгаарлалтаа чангатгаж, зэсийн баяжмалын экспорт түр хугацаагаар зогсож, нүүрсний экспорт удааширсан бөгөөд оны эхний хагаст 9.3 сая тонн нүүрс экспортлосон нь төсөөллөөс 7 сая тонноор дутуу байв. 2021 оны сүүлийн хагаст нүүрсний экспорт төдийлөн сэргээгүй ба өнгөрсөн онд нийт 15.7 сая тонн нүүрс экспортлосон нь төсөөллөөс даруй 20 гаруй сая тонноор бага үзүүлэлт болсон юм.¹ Өөрөөр хэлбэл, Монгол Улс 2021 онд нүүрсний экспортоос 3.7

¹ 2020 оны эцэс болон 2021 оны 1 дүгээр улирлын төсөөллөөр нүүрсний экспорт 2021 онд 36 сая тоннд хүрэх төсөөлөлтэй байсан.

тэрбум ам.долларыг алдаж, энэ хэмжээгээр экспортын орлогын алдагдсан боломжийн зардал нэмэгдсэн байна. Түүнчлэн, 2021 оны 10 дугаар сарын дунд үеэс Замын-Үүд боомт хаагдсанаас гадна тээврийн зардал огцом нэмэгдэж, импортын барааны үнэ, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг давхар өдөөв. Олон улсын тээвэр, логистикийн асуудал сайжрахгүй байгаагийн зэрэгцээ 2021 оны эцсийн байдлаар Замын үүд-Улаанбаатар чиглэлийн тээврийн зардал цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 22 дахин нэмэгдсэн байна. Газрын тосноос бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 2021 онд биет хэмжээгээр өмнөх оны мөн үеэс буурсан дүнтэй байсан нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл буурах гол нөлөөг үзүүллээ. Түүнчлэн, тээвэр, логистикийн доголдол, хилийн гацаа, тээвэрлэлтийн үнэ нэмэгдсэн, эрчим хүчний үнийн өсөлт зэрэг нь манай улсын гадаад худалдаа, төлбөрийн тэнцэлд томоохон хязгаарлалтын нэг болсон хэвээр байна.

Орлогын суваг: Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны эхний саруудад гадаад худалдаа буурч, экспортын орлого хумигдсан нь төсвийн орлогод сөргөөр нөлөөлж, 2020 оны эхний хагас жилд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 79.6 хувийн гүйцэтгэлтэй гарав. Төсвийн орлого буурч, зардал тэлж эхэлснээр төсвийн алдагдал нэмэгдэж, төсвийн тэнцэл 2020 онд 4.5 их наяд, 2021 онд 2.9 их наядын алдагдалтай гарлаа. Энэ нь нэрлэсэн ДНБ-ий 12.2 хувь болон 6.8 хувьтай тэнцэх дүн юм. Төсвийн орлого буурснаас гадна дотоодод тогтоосон хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын арга хэмжээнүүдийн улмаас эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагаа хумигдаж, уул уурхай, барилга, худалдаа, үйлчилгээ, тээврийн салбарууд цар тахлын цохилтод хүчтэй нэрвэгдэв. Харин хөдөө аж ахуй, мэдээлэл холбооны салбарт цар тахлын үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байлаа. Цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь аж ахуйн нэгжүүдэд орлого буурах, зардлаа танах, үйлдвэрлэлээ бууруулах, цаашлаад үйл ажиллагаагаа түр эсвэл бүрэн зогсоох байдлаар илэрсэн бол өрхүүдэд ажил эрхлэлт буурах, цалин, хөлсний орлого нь тасалдах, өрийн дарамт нь нэмэгдэх зэргээр илэрч байв.

Зээлийн суваг: Ковид-19 цар тахлын үед эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал нэмэгдэн, банкууд зээл олгох шалгуураа чангаруулж, зээл олголтоо хумьж эхэлсэн. Банкуудын шинээр зээл олголт 2020 онд өмнөх оноос 6 хувиар, нийт зээлийн үлдэгдэл 5 хувиар тус тус буурч байв. Цар тахлаас шалтгаалан эдийн засгийн уналт бий болж, аж ахуйн нэгж, байгууллагуудын орлого тасарсан ийм нөхцөлд зээл олголт хумигдаж, санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжгүй болвол эдийн засгийн уналтыг улам гүнзгийрүүлэх эрсдэлтэй. Энэхүү цикл нь удаан хугацаанд үргэлжилвэл банк, санхүү, эдийн засгийн хямралыг гүнзгийрүүлэх төдийгүй санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулах тул зохицуулагч байгууллагуудын зүгээс хүндрэлийг зөөлрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон салбаруудын өрийн дарамтыг бууруулах зорилгоор зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх зэрэг зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээс гадна аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор 10 их наядын арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд банкуудын зээл олголт нэмэгдэж, эдийн засгийн салбаруудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон төлбөрийн чадварын хүндрэлээс сэргийлсэн юм. Банкуудын

шинээр олгосон зээл 2021 онд өмнөх оноос 43.1 хувиар нэмэгдсэнээс хэрэглээний зээл 22.7 хувиар, бизнесийн зориулалттай зээл 47.4 хувиар тус тус өсжээ.

Зээл олголт нэмэгдсэнээс гадна аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн жигнэсэн дундаж хүү буурсан нь зээлийн үйлчилгээний дарамтыг хөнгөлөх чухал дэмжлэг болсон юм. Түүнчлэн, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ болон бусад санхүүжилтийн хэрэгслээр дамжуулан зээлийн дэмжлэгийг үзүүлж, 2021 онд ЖДҮ-д шинээр олгосон зээл өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн байна. Үүнээс боловсруулах, худалдаа, барилгын салбарт олгосон зээл хамгийн өндөр дүнтэй байв. Ийнхүү зохицуулагч байгууллагуудын зүгээс хөнгөлөлттэй зээл, санхүүжилтүүд, бусад бодлогын арга хэрэгслээр дамжуулан зээл олголтыг нэмэгдүүлэх замаар аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлэх, мөнгөн урсгалыг нь тасалдуулахгүй байх, өрийн хэт дарамт үүсгэхгүй байх, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлд шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна.

Ковид-19 цар тахлын үед банк, санхүүгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монголбанк нь Ковид-19 цар тахлын санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэхэд чиглэсэн дараах зохицуулалтын арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлэв. Үүнд:


1. Санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлж, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, улмаар эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг бууруулав. Тухайлбал, Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 болон 11 дүгээр сарын хурлуудаар төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг нийт 4.5 нэгж хувиар бууруулж, 6 хувьд хүргэв. Уг түвшинг 2021 оны турш хэвээр хадгалж, 2022 оны 1 дүгээр сард 2 нэгж хувиар нэмэгдүүлж 8 хувьд хүргээд байна.
2. Цар тахлын улмаас эргэн төлөлтөд хүндрэл учирсан хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгаж, зээлд бүтцийн өөрчлөлт хийх боломжийг Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4, 8, 11 дүгээр сарын ээлжит бус хурлуудаар олгов. Энэхүү арга хэмжээ нь 2021 оны 7 дугаар сард дууссан бөгөөд нийт 146,704 зээлдэгчийн 1.2 их наяд төгрөгийн хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийгджээ.
3. Монголбанк, Сангийн яам, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК болон банкууд хамтран хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах шийдвэрийг 2020 оны эхнээс хойш нийт 4 удаа гаргав. Энэхүү хөнгөлөлтийн хүрээнд 2022 оны 2 дугаар улирлыг дуустал 61 мянган өрхийн 3.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулжээ.
4. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын зарим зохицуулалтуудыг сулруулав. Тухайлбал, Монголбанк нь цар тахалтай холбоотойгоор банкны актив ангиллын журамд өөрчлөлт оруулж, 2020 оны 3 дугаар сараас эхлэн иргэдийн ипотека, хэрэглээний зээлд тогтоох хугацааны ангиллыг “хэвийн” зээлийн хувьд 15 хоногоос 90 хоног, “анхаарал хандуулах”

зээлийн хувьд 91 хоногоос 120 хоног, “чанаргүй” зээлийн хувьд 121-ээс дээш хоног байхаар тус тус нэмэгдүүлсэн. Түүнчлэн, энэхүү хөнгөлөлттэй зохицуулалтыг 2021 оны 8 дугаар сараас эхлэн шат дараатай бууруулж “анхаарал хандуулах” зээлийн хугацаа хэтэрсэн хоногийг 75, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 2 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлж байна. Үүнээс гадна хэрэглээний болон бизнесийн зээлийн эргэн төлөлтийн бүтцийг өөрчлөх байдлаар гэрээг өөрчилсөн тохиолдолд уг зээлийг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүйгээр, эцсийн ангиллыг хэвээр тогтоов. Үүний үр дүнд бизнесийн зээлийн бүтцийг өөрчлөхөд хязгаарлалтгүй болж, банкууд 2021 оны эцсийн байдлаар 1,752 ААН-ийн 1.9 их наяд төгрөгийн үлдэгдэл бүхий бизнесийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгээд байна.

5. Монголбанкнаас 2020 оны 3 дугаар сард “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д түр хугацааны өөрчлөлт оруулж, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 25 хувиас 20 хувь хүртэл бууруулав. Энэхүү шийдвэрийн хэрэгжих хугацаа 2021 оны 6 дугаар сард дууссан болно.
6. Банкны зээл олголтыг дэмжих зорилгоор банкны системд нөөц хөрөнгө бүрдүүлэх арга хэрэгслүүдийн хэрэгжиж эхлэх хугацааг хойшлуулав. Тодруулбал, банкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервал (capital buffer)-ыг бүрдүүлэх хугацааг 2022 оны 1 дүгээр сарын 1 (1 хувь), 2022 оны 7 дугаар сарын 1 (2 хувь) өдөр хүртэл хойшлуулав.

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2022/5/2-ний байдлаар 3,795.3 сая ам.долларын болон 198.0 сая юанийн нийт 2054 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



Монголбанк 2022 оны 4 дүгээр сард 358.9 кг үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 3.8 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 453 кг-аар буурсан үзүүлэлт юм. 4 дүгээр сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 2.4 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 25.5 кг үнэт металл худалдан авсан.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж ханш 2022 оны 4 дүгээр сард 188,943 төгрөг байв.

График 1. 2020.09-2022 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (кг)




График 2. 2010-2022 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)






График 3. 2022 оны 4 дүгээр сард Монголбанкны худалдан авсан алтны үнэ (төгрөг/грамм)




2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

Дүрслэл 1. Ипотекийн хөтөлбөрийн зээлийн дүн (тэрбум ₮) болон зээлдэгчийн тоо, сараар



Цар тахлын хуулийн дагуу хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр 2020 оны 4 дүгээр сараас 2022 оны 7 дугаар сар хүртэл 4 удаа хойшлуулсан (Дүрслэл 2). Сүүлийн буюу 5 дахь удаагийн төлбөр хойшлуулалтаар 3.4 их наяд гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 63,171 зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлууллаа. Дээрх зээлдэгчид 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оныг дуустал нийт 195.12 тэрбум төгрөг (77.9 тэрбум үндсэн төлбөр, 117.3 тэрбум төгрөгийн хүүний төлбөр)-ийн төлбөрийг хойшлуулсан буюу уг дүнгээр шууд дэмжлэг болсон байна.

Дүрслэл 2. Ипотекийн төлбөр хойшлуулсан зээл (тэрбум ₮) болон зээлдэгчийн тоо





Хүүхэд залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн оновчтой шийдвэр гаргахад суралцуулах, ирээдүйн амжилттай бизнес эрхлэгчдийг төрүүлэх зорилготой “Дэлхийн мөнгөний долоо хоног” олон улсын аянд манай улс 9 дэх жилдээ оролцов. Жил бүр онцолсон уриан дор болдог уг аян 2022 онд “Мөнгөө ухаалгаар удирдаж, ирээдүйгээ өөрсдөө бүтээе” уриаг зарласан юм. Монголбанк энэхүү аяныг Монгол Улсад санаачлан хэрэгжүүлснээр хамтран оролцогч байгууллагуудын тоо жил ирэх бүр нэмгдсээр байна. Монголын хүүхэд, залуучуудын санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх, мөнгөө ухаалгаар зарцуулах, санхүүгийн мэдлэгээ гэр бүл болон нийгэмд хуваалцахад нь дэмжлэг болох сургалт, мэдээ мэдээллийг түгээхэд хамтран оролцогч байгууллагууд өндөр идэвх, санаачлага гаргаж ажилласан юм. Энэ хүрээнд зохион байгуулсан эссэ бичлэгийн уралдаанд тэргүүлсэн бүтээлийг уншигч Танд толилуулж байна.

МОНГОО ЗӨВ УДИРДЬЯ

Танд сар бүр 30 өндөг өгөх бөгөөд та түүнийг ухаалаг зарцуулж амьдрах ёстой гэж бодъё. Хэт их идвэл дараагийн өдрүүддээ өлсөнө. Харин бага иднэ гэдэг угаас боломжгүй. Учир нь өдөрт нэг ширхэг өндөг л идэж байж амь зогоох юм. Гэхдээ эдийн засгийн хямралаас болж танд сардаа 25-хан ширхэг өндөг өгөх болжээ.

Тэгээд түүнийгээ “Хэрхэн зөв зарцуулах вэ?” гэж бодвол нэг бол өндөг нь дутна, эсвэл ухаан нь дутна. Ухаан дутсан ч амьдрах ёстой тул яаж ийж байгаад л нэг арга олох ёстой. Миний хувиас зөвлөх хамгийн шилдэг арга бол өндгөө тахиа болгох. Гэвч яаж тахиа болгох аргаа мэдэхгүй, аль сагсанд хийвэл зөвийг мэдэхгүй учраас маш олон аргаар

туршиж үзэх ёстой. Бүх өндгөө нэг сагсанд хийчихвэл асуудал үүсвэл бүгд хагарах аюултай. Тиймээс өндөгнүүдээ өөр өөр сагсанд хийж байж үржүүлж чадна.

Үндэсний статистикийн хорооны 2021 оны 4-р улирлын статистик үзүүлэлтээр манай орны дундаж цалин 1.4 сая төгрөг, медиан цалин нь 1 сая төгрөг байна. Гэхдээ Монгол улсын дундаж өрхийн орлогын зардлын 60% нь гэхэд байрны түрээсийн мөнгө дангаараа эзэлчихдэг. Үлдсэн хувийг амь зуухдаа хэрэглэнэ. Хоол хүнс, гутал хувцас, амттан шимттэн гээд авдаг арван цаас нь хаа сайгүй л хэрэг болно. Гэвч инфляц өссөнөөс үүдэж өмнө нь авдаг байсан зүйлсээ ч

хангалттай авч чадахаа болиход хүрээд байна.

“Ямар азаар ажил хийдэг юм бэ, яг сайхан мөнгөгүй амьдарч байна. Ажил хийдэггүй байсан бол өдийд өрөнд орж байхгүй юу” гэдэг нь хөгжилтэй яриа хэдий ч өнөөгийн нийгмийн хүндхэн байдлыг харуулж байна. Нээрээ л бид зөвхөн цалингаараа амьдарна гэвэл үнэхээр “үлгэрийн далай” болсон цаг үе иржээ. Илүү мөнгө олохын тулд давхар ажил хийж болох ч миний амьдрал сүүлдээ юуны төлөө билээ гэдгээ ойлгохоо байхад хүрэх байх. Үүнээс харвал нөгөө нэг дутаад байгаа ухаанаа хүргэхээс өөр аргагүй. Насаараа бүсээ чангалах уу? Эсвэл байгаа мөнгөө ухаан зарж өсгөх үү?

Нөгөө л нэг өндөг хуваах зарчмаараа мөнгөө олон хувааж өсгөх нь хамгийн зөв алхам

юм. Ганц найдвараа тавиад мөнгөө хадгалсан банк, банк бус, нэгдэл хоршоо дампуурвал хэцүүхэн юм болно. Тэр тусмаа одоо үеийнх шиг найдвартай найдваргүй нь мэдэгдэхгүй маш өндөр эрсдэлтэй ч тэрийгээ дагаад өгөөж өндөртэй койнууд их бий. Сэтгэл хөдлөлөөрөө койн авчихсан чинь бүх мөнгөө алдчихвал дуус дуус. Мөнгөө өсгөх, өгөөж өндөртэй байлгах чухал хэдий ч эрсдэл хэмээх найз хэзээд дагаад ирдэг тул өгөөж эрсдэл хоёрынхоо тэнцвэртэй түвшинд барих нь их чухал. Эцэст нь харвал нэг хэсгийг нь өгөөж багатай ч найдвартай өсөхөөр нь хадгаламжид хийж, хамгийн эрсдэл багатай засгийн газрын бондуудыг худалдан авч, нөгөө хэсгийг нь их өгөөж өгөх шинэхэн зарлагдаж байгаа IPO-д оруулж, за тэгээд сайн

судалж байгаад алдсан ч яах вэ, алах гээд байна гэж бодсон койноо авч болж байна. Энэ мэтчилэнгээр мөнгөө тараан байршуулж өгөөжөө хамгийн өндөр байлган эрсдэлээ бууруулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, өндөгнүүдээ хамгийн зөв сагсандаа зөв хэмжээтэйгээр хийх хэрэгтэй гэсэн үг.

Гэхдээ эрсдэл өгөөжийнхөө харьцааг зөв олуулдаг тэнцвэрийн сагс гэж байдаг. Тэр нь БОЛОВСРОЛ. Боловсрол гэх энэ сагсанд өндөгнүүдээ хийвэл үлдсэнээ зөв сагснуудад хийж мөнгөө өсгөж чадна. За тэгээд миний хэлснээр энэ бүх сагснуудад өндгөө байршуулбал эргээд харахад бүсээ чангалах биш бүсээ давсан гүзээтэй болно биз.

**GLOBAL
MONEY
WEEK®**



**GLOBAL
MONEY
WEEK**



Use #GlobalMoneyWeek2022

GLOBAL MONEY WEEK 2022

 www.globalmoneyweek.org

21-27 March 2022